



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,

Утас/факс: 7045-3317,

Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2025.04.22 № 289
танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН БАРУУНТУРУУН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ "МОНГОЛ АРДЫН НАМ"-ЫН
УДИРДЛАГА ТАНАА

Хандивын тайлангийн дүгнэлт

Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох Монгол Ардын намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Увс аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6 дахь заалтад заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Увс аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох Монгол Ардын намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

8525020892

Дүгнэлт

Монгол Ардын нам нь ээлжит бус, нөхөн болон дахин сонгуульд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ





УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,

Утас/факс: 7045-3317,

Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2025.04.22 № 292

танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН БАРУУНТУРУУН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ "МОНГОЛ АРДЫН НАМ"-ЫН
УДИРДЛАГА ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-д заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох "Монгол Ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тус тус шалгуур болгон авч үзсэн.

8525020884

Дүгнэлт

“Монгол Ардын нам”-ын Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Монгол Ардын нам”-ын мөрийн хөтөлбөр хуудас материал хавсаргав.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



М.БАТСУУРЬ

М.БАТ-АМГАЛАН

Б.АВИРМЭД

Р.АЮУШ

Б.ОДГЭРЭЛ

Т.БАТСҮХ



МОНГОЛ АРДЫН НАМ

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ – УВС 2024-2028


МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “АЛСЫН ХАРАА – 2050”, Шинэ сэргэлтийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн бодлого, УИХ-ын сонгуульд оролцсон МАН-ын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт үндэслэн, аймгийнхаа нийт ард иргэд, бизнес эрхлэгчид, мэргэжлийн байгууллагуудын саналыг тусган, орон нутгийн ИТХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсрууллаа.

НЭГ: ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Баруун бүсийн хөгжил-Увс аймгийн оролцоо:

- ✓ *Эко үйлдвэрлэл, эко эдийн засаг*
- ✓ *ХАА, хөнгөн, хүнсний үйлдвэр*
- ✓ *Байгаль, тусгай сонирхлын болон хил орчмын аялал жуулчлал*
- ✓ *Эдийн засгийн коридорыг түшиглэсэн боомт, тээвэр логистик*
- ✓ *Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бүс нутагтаа манлайлна. Үүнд:*



Увс аймаг

- 1.1.1 Ховд-Улаангом чиглэлийн 163 км автозамыг барина.
- 1.1.2 Улаангом-Баруунтуруун чиглэлийн 195 км хатуу хучилттай автозамыг ашиглалтад оруулна.
- 1.1.3 Увс аймгийн нисэх буудлыг 4С ангиллын нисэх буудал болгон өргөтгөнө.
- 1.1.4 Увс аймгийн Наранбулаг сумын Харганатын төмрийн хүдрийн уурхайг түшиглэн гангийн үйлдвэр байгуулна.
- 1.1.5 Увс аймгийн Улаангом сумд олон улсын стандартад нийцсэн Чацаргана боловсруулах үйлдвэр байгуулна.
- 1.1.6 Увс аймгийн Баруунтуруун суманд баруун бүсийн хэрэгцээг хангах гурил, тэжээлийн үйлдвэр байгуулна.
- 1.1.7 Улаангомьн хиймэл нуур, Давстын Торхилог, Баруунтурууны Зүүнтуруун, Тээлийн боом, Тариалан, Түргэн, Тэс сум зэрэг газар тариалан эрхлэх, тэжээлийн ургамал тариалах боломжтой бүс нутгуудад хөв цөөрөм, услалтын систем байгуулна.
- 1.1.8 Улаангом суманд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв, Хүүхэд залуучуудын хөгжлийн төв цогцолборыг тус тус байгуулна.
- 1.1.9 Увс аймгийн Улаангом суманд байрлах дулааны 2-р станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх өргөтгөл хийж, дулааны шинэ станц барьж, үйлдвэрийн болон гэр хорооллын инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.10 Алтайн нуруу, их нууруудын экосистемд түшиглэсэн адал явдалт, ангийн, угсаатан зүй, хил орчмын болон хил дамнасан аяллын чиглэлийг хөгжүүлэх ОЛОН ЯСТНЫ аялал жуулчлалын кластер бүсчлэлээр хөгжүүлж, Их нууруудад усан зам тогтоож аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.
- 1.1.11 Увс, Хяргас нууруудад усан зам тогтоож том завь, усан онгоц явах боломжтой болгон аялал жуулчлалыг дэмжинэ.

ХОЁР: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

рүүл мэнд

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрээнд:

- 2.1.1 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх “Эрүүл амьдрахуй” хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлнэ.
- 2.1.2 Архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээг бууруулах, амиа хорлолт, цахим тоглоом зэрэгт донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдэд эрүүл мэнд, нийгэм, сэтгэлзүйн тусламж үйлчилгээ үзүүлэх “Өгөөмөр – сэтгэл” төвийг байгуулан ажиллана.
- 2.1.3 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, дундаж наслалтын хүйсийн ялгаатай байдлыг багасгах бодлого боловсруулан, хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллана.
- 2.1.4 Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан “Гэртээ эрүүлээр гэрэлтэе” системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн эрт илрүүлгийг нэмэгдүүлнэ.
- 2.1.5 “Элэг бүтэн Монгол”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол”, “Эрүүл чийрэг эр хүн” хөтөлбөрүүдийг орон нутгийн онцлогтой уялдуулан үргэлжлүүлэн, хэрэгжүүлнэ.
- 2.1.6 “Эрүүл шүд - Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээнд:

- 2.1.7 Эрүүл мэндийн үйлчилгээнд шаардлагатай унаа, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тасралтгүй хангаж, яаралтай тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулна.
- 2.1.8 Эрүүл мэндийн байгууллагын оношлогооны чадавхыг сайжруулан, иргэн бүрийг эрүүл мэндийн иж бүрэн оношилгоонд хамруулж, аймагтаа эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.1.9 Иргэдийн эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, сумын эрүүл мэндийн төвүүдийн оношлогоо, мэдээллийг дотоодод болон олон улсад цахимаар солилцох тогтолцоо бүрдүүлнэ.
- 2.1.10 Цаг авах, шинжилгээний хариу авах, эмчээс зөвлөгөө авах зэрэг үйлчилгээг ухаалаг системтэй холбох хөтөлбөрийг хэрэгжүүлж, дараалал, хүндрэл чирэгдлийг бууруулна.

Эрүүл мэндийн салбарын бүтээн байгуулалтын хүрээнд:

- 2.1.11 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн шинэ барилга барих, сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр хангах төслийг хэрэгжүүлж, сумдын ЭМТ-ийн барилгын засвар, өргөтгөлийг үе шаттай хийн, ариун цэврийн байгууламжтай болгоно.
- 2.1.12 “Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний төв” байгуулж хавдрын эрт үеийн илрүүлэлт, урьдчилан сэргийлэлтэд онцгойлон анхаарч аймагтаа хорт хавдрын мэс засал хийдэг болно.
- 2.1.13 Аймгийн төрөх эмнэлгийн барилгад их засвар хийж шинэчлэл хийхээс гадна бүх суултуурыг “Бидэ – ухаалаг” суултууртай болгоно.
- 2.1.14 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, СЭМТ, ӨЭМТ, АНЭ-ийн ачааллыг бууруулах, үйлчилгээг иргэнд ойртуулах зорилгоор НЭМТ-ийн барилгын ажлыг эхлүүлэх.

Эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааны хүрээнд:

- 2.1.15 Аймагт нарийн мэргэжлийн эмч, сувилагч, мэргэшсэн асрахуйн ажилтнуудыг бэлтгэх бодлогыг байнга хэрэгжүүлж, тэднийг орон нутагт тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах.
- 2.1.16 Эрүүл мэндийн салбарт аав, ээж нь ажиллаж байсан одоо ажиллаж байгаа эмч, сувилагч зэрэг эрүүл мэндийн чиглэлээр дотоод болон гадаад их дээд сургуульд суралцаж буй оюутан, залуусын сургалтын төлбөрийг орон нутгаас хөнгөлөх, ажлын байраар хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.
- 2.1.17 Сум, багийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын хүрээнд “Сумын залуу эмч” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, нийгмийн баталгааг хангаж ажиллах.

2.2 Боловсрол

- 2.2.1 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулан ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 2.2.2 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх өндөр ачаалал бүхий бүлгүүдэд ээлжийн багш ажиллуулна.
- 2.2.3 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, ганцаарчилсан сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж боловсролд тэгш хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багшлах боловсон хүчнийг чадваржуулан, үе шаттай мэргэжил дээшлүүлнэ.
- 2.2.4 Боловсролын цагалбарыг сум, орон нутгийн онцлог, байгаль цаг уурын нөхцөл, өв уламжлал, амьдралын хэв шинж, ахуйд нийцүүлж уян хатан зохицуулна.
- 2.2.5 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлж “Хүүхдийн хөгжил, хамгааллын төв” болгоно.
- 2.2.6 Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолыг стандартад нийцүүлэн шинэчилж, орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.
- 2.2.7 Сумдын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн их засварыг ашиглалтын чанар, цаг хугацааны эрэмбээр үе шаттай гүйцэтгэж, орчин нөхцөлийг сайжруулна.
- 2.2.8 Улаангом политехник коллежийн хичээлийн “Б” байрны барилгад их засвар хийнэ.
- 2.2.9 Хүүхдийн оюуны чадварыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх. /Оюун ухааны академи, STEM боловсрол, Зохион бүтээх, инженер, Робот, код бичих, мэдээллийн технологийн сургалтыг дэмжиж, клуб, дугуйлан байгуулахад дэмжлэг үзүүлэх, багш нарыг чадваржуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, түүхий эд авахад нь дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.10 IELTS, TOEFL бэлтгэх сургалтын төвүүдийг байгуулах, гадаад хэлний багш нарыг чадваржуулах, гадаадын сайн дурын мэргэжилтнүүдийг сургуулиудад ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.11 Мэргэжил сонголт, гадаадад суралцахад зөвлөгөө өгөх төвүүдийг байгуулах, гадаадын их сургуулиудын салбар суурин төлөөлөгчидтэй холбох арга хэмжээг хэрэгжүүлнэ;
- 2.2.12 Өмнөговь, Баруунтуруун, Өндөрхангай суманд бүсийн Математик, англи хэлний төрөлжсөн ахлах сургууль байгуулна.
- 2.2.13 Улаангом суманд кембрижийн олон улсын хөтөлбөртэй сургууль, их, дээд сургуулиудын харьяа байгалийн ухааны төрөлжсөн ахлах сургууль байгуулж, биеийн тамирын сургалттай 5-р сургуулийг спорт, урлагийн төрөлжсөн дунд сургууль болгон бүтцийг өөрчилж, хүний нөөц, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл хийнэ.

- 2.2.14 “Сайн сургууль”, “Сайн цэцэрлэг” арга хэмжээг хэрэгжүүлж сургалтын чанар, үр дүн, менежментээр тухайн жилд амжилт гаргасан байгууллагуудыг урамшуулах үр дүнд суурилсан урамшууллын төгтолцоог бүрдүүлнэ.
- 2.2.15 Улаангом ПТК-ын хүчин чадлыг өргөжүүлж, сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, эрэлттэй мэргэжлээр суралцах элсэгчдийн тоог нэмэгдүүлж, хөтөлбөрийн шинэчлэл хийх, ШУТИС-ийн салбар сургууль болгон өргөжүүлнэ.
- 2.2.16 Залуу багш нарыг ипотекийн зээлд хамрагдахад нь урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэх, эрэлттэй судлагдахууны багш нарт аймгийн болон сумын Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох, “Залуу багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2.17 Багш, ажилтнуудын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, өндөр хөгжилтэй орнуудад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, замын зардлын болон бусад дэмжлэг үзүүлэх, элсэлтийн шалгалт, гүйцэтгэлийн үнэлгээ, улсын чанартай олимпиад, спорт, урлагийн уралдаан тэмцээнд өөрөө болон шавь нараа амжилттай бэлтгэн оролцуулсан багш нарыг урамшуулах “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.2.18 Багш нарын хүний нөөцийн хомсдолыг шийдвэрлэх хүрээнд багш анги, цалинтай оюутан арга хэмжээг хэрэгжүүлж, аймаг, сумын захиалгаар багшаар суралцаж буй оюутнуудад дотуур байрны төлбөр, амьжиргааны дэмжлэг үзүүлнэ;
- 2.2.19 Багш, ажилтнуудад орон нутгийн 80%-аас доошгүй нэмэгдэл олгоно.
- 2.2.20 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх хүрээнд бүх багш нарыг орчин үеийн шаардлагад нийцсэн зөөврийн болон суурин компьютероор хангах, “Багшийн хөгжлийн танхим”-ыг байгуулах, шинэчлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэнэ.
- 2.2.21 Байгалийн ухааны сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх, инженерийн боловсролын суурийг бага, дунд ангиас тавих хүрээнд ахлах сургуульд 2, 9 жилийн сургуульд тус бүр 1 иж бүрэн байгалийн ухааны кабинет байгуулах, хуучин кабинетуудыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, бага анги, цэцэрлэгийн ахлах бэлтгэл бүлэгт STEM сургалтын танхим байгуулна.
- 2.2.22 Ерөнхий боловсролын сургууль бүрд 20-25 хүүхдийн хүчин чадал бүхий иж бүрэн цахим сургалтын танхимыг 2-оос доошгүй байгуулах, хуучин танхимуудыг шинэчилж, 1 компьютерт ногдох хүүхдийн тоог 10-д хүргэнэ.

2.3 Орлоготой иргэн

- 2.3.1 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 2.3.2 Жижиг дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулж, өсөн дэвжих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3.3 Ажил эрхлэлтийн бүхий л хэлбэрийг дэмжиж байнгын шинэ ажлын байрыг тогтворжуулна.
- 2.3.4 Иргэдийн туршлага, ур чадварт түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжиж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээлд хамруулах бодлого баримтална.

2.4 Аз жаргалтай амар амгалан гэр бүл

- 2.4.1 Хүн бүр угийн бичгээ хөтлөх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, удмын сангаа хамгаалах ажлыг эрчимжүүлнэ. – Урамшууллын систем – ТББ
- 2.4.2 Хашаандаа инженерийн дэд бүтэц бүхий хувийн сууц барьж буй өрхийг ипотекийн зээлд хамруулж, бүх талаар дэмжиж ажиллана.

2.4.3 Сумдад очиж ажиллах өндөр ур чадвар бүхий багш, эмч нарыг урамшууллаар дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.4.4 Орон сууц

- Баялгийн сан, Нийгмийн даатгалын сангаар дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлээр иргэдийг орон сууцжуулах ажлыг хууль эрх зүйн орчны дагуу аймагт зохион байгуулна.

“Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумдын иргэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлах санаа санаачилга, идэвхтэй хандлагыг олон хэлбэрээр дэмжинэ.
- “Амины орон сууц” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Хүүхдийн хөгжил

үүхдийн хөгжил, авъяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшлийн дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгот ажлуудыг үе шаттай хэрэгжүүлнэ.

үүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, гэрлэн дохио, хурд сааруулагч, камертай болгоно.

үүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.

үүхдийн хөдөлмөр амралтын зуслан байгуулж ажиллуулахыг дэмжинэ.

үүхдийн паркийг шинээр төлөвлөн байнгын ажиллагаатай болгоно.

аруун бүсийн хүүхдийн зуслантай болно.

үүхдийн хөгжлийн ордонтой болно.

2.5.8 “Дэлхийн хүн” боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж хүүхэд залуусыг гадаадын их сургуульд элсэн суралцах боломж нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6 Залуучуудын хөгжил

2.6.1 Залуучууд, залуу гэр бүлийг орлогод нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлнэ. Сумдад залуу гэр бүлд зориулсан орон сууцжуулах бодлого хэрэгжүүлнэ.

2.6.2 Гэр бүл, хүүхэд, оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин бий болгоход зориулсан төвүүд болон кино театр, спорт цогцолбор, цэцэрлэгт хүрээлэнтэй болно. Дуусаагүй ажлуудын гарц шийдлийг олж ашиглалтад оруулна.

2.6.3 Гадаад, дотоодод их дээд сургууль төгссөн залуучуудаа нутагтаа эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж, урамшуулах тогтолцоог бүрдүүлсэн цахим мэдээллийн систем бий болгоно.

2.6.4 Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.6.5 Жил бүр 500 оюутныг 1 сая төгрөгийн тэтгэлэгт хамруулж сурах боломж нөхцөлийг нь нэмэгдүүлнэ.

2.6.6 Залуучуудын гарааны бизнесийг бүхий л хэлбэрээр дэмжиж төрийн оролцоотойгоор дундын оффисе /HUB office / байгуулан өсөж хөгжих боломжоор хангаж ажиллана.

2.6.7 Орон нутагт шилжин ирж ажлын байр бий болгож буй залуу гэр бүлийн бизнес эрхлэх болон хөдөлмөр эрхлэх орчин нөхцөлийг бий болгох;

- 2.6.8 18-34 насны залуусын гарааны бизнес “Start-Up” хөтөлбөрийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс нэмэгдүүлж гадны болон дотоодын төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг татаж хамтран ажиллах замаар дэмжинэ.
- 2.6.9 Сайн дурын залуусын үйл ажиллагааг дэмжих “Event” апп нэвтрүүлнэ.

2.7 Тусгай хэрэгцээ / хөгжлийн бэрхшээл /-тэй иргэдийн хөгжил

- 2.7.1 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэд хэрэгцээт үйлчилгээгээ авах нөхцөлийг төрийн болон бусад байгууллагад бүрдүүлнэ.
- 2.7.2 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн эрх оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа болон хөдөлмөр эрхлэлтийг нь нэмэгдүүлнэ.
- 2.7.3 Шинээр барьж байгаа барилга байгууламж, нийтийн эзэмшлийн гудамж талбайд тусгай хэрэгцээт иргэний явах зам, талбайг бий болгож ээлтэй орчин бүрдүүлнэ.

2.8 Ахмадын хөгжил

- 2.8.1 Ахмад настны чөлөөт цагаа өнгөрөөх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвүүдийг бүх сумдад бий болгож үйл ажиллагааг нь тогтмолжуулна.
- 2.8.2 Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх зөвлөх үйлчилгээний ажил эрхлэлтийг үр дүнтэй хэлбэрээр үргэлжлүүлнэ.
- 2.8.3 Аймгийн “Ахмадын ордон” шинээр барьж чөлөөт цагаа үр дүнтэй өнгөөрөх, хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.8.4 Аймгийн ахмадын сувилалд өргөтгөл барьж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.9 Соёл урлаг

- 2.9.1 Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх чанар хүртээмжийг дээшлүүлж, нийтийн номын сангуудыг харилцан мэдээлэл солилцох, цахим сан хөмрөг үүсгэх ажлуудыг үе шаттай зохион байгуулж ажиллана.
- 2.9.2 Нүүдлийн соёл иргэншил, өв соёлоо сурталчлах, соёлын аялал жуулчлал, соёлын бүтээгч үйлдвэрлэл хөгжүүлж эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.9.3 Түүх, соёлын дурсгалт зүйлүүдийн зэрэглэл тогтоож, хамгаалалтын бүсийг бий болгож бүс нутгийн онцлогт тулгуурлан хөгжүүлэх, олж тогтоох түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлах, өв соёлыг нэр төрлөөр нь хөхүүлэн дэмжиж олон нийтийн соёлын боловсролыг дээшлүүлнэ.
- 2.9.4 Аймгийн “Ойрад театрын шинэ барилгыг ашиглалтад оруулж” олон улсын стандарт жишигт хүргэж шинэ дэвшилтэд менежмент, маркетинг хэрэгжүүлнэ.
- 2.9.5 Увс аймгийн музейг орон нутгийн угсаатан соёл ахуйд байгалийн онцлог бүс, бүслүүрт тулгуурлан соёлын аялал жуулчлалыг бааз суурь болгон олон улсын стандарт нийцүүлж шинэ байртай болгоно.
- 2.9.6 Бөхмөрөн, Сагил, сумын соёлын төвүүдийн барилгыг шинээр барих, Тариалан сумын өргөтгөл барина.
- 2.9.7 Соёл урлагийн байгууллагуудыг тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах, соёлын төвүүдийн тайзыг лед дэлгэцтэй болгоно.
- 2.9.8 Театрын урын санг баяжуулах нутгийн онцлогт тохируулан брэнд бүтээгдэхүүн бий болгож дэлхий нийтэд өрсөлдөх чадварыг дэмжиж ажиллана.

2.10 Спортын хөгжил

- 2.10.1 Спортын зарим төрлөөр өсвөрийн шигшээ баг байгуулж, бэлтгэл сургуулийг тогтмолжуулж, мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллуулж, улс, тив, дэлхийн чанартай тэмцээнд амжилт гаргасан тамирчдад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
- 2.10.2 Хүн амын эрэлт хэрэгцээг үндэслэн зарим сумдад шинээр спорт заал барих, их засвар хийх ажлыг эрэмбэлэн үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.10.3 Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, шинэ тутам хөгжиж байгаа цахим болон спортын бусад төрлийн орчин нөхцөл, талбай бүхий дэд бүтцийг байгуулахыг дэмжинэ.
- 2.10.4 Аймгийн сургуулиудыг жижиг хөлбөмбөгийн талбайтай болгох, цаашдаа сумдад бий болгож эхэлнэ.
- 2.10.5 Улаангом сум дахь нийгэмлэг спорт заалыг дахин төлөвлөлтөд оруулж спорт цогцолбор барина.
- 2.10.6 Аймгийн төвийн бүх баг, сумын төвүүдэд стандартын 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулна.
- 2.10.7 Аймгийн спортын ордны барилгад их засвар хийж орчин нөхцөлийг сайжруулна.

ГУРАВ : ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

2.1 Хөдөө аж ахуйн хөгжил-Хөдөөгийн сэргэлт

- 2.1.1 “Шинэ хоршоо” хөдөлгөөн, хөдөөгийн сэргэлтийн бодлогыг аймагт хэрэгжүүлж малчид, тариаланчдын ая тухтай амьдрах орчныг сайжруулж тогтвортой орлогын эх үүсвэртэй болгоно.
- 2.1.2 Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослуулан хөгжүүлж, сумдын онцлог нөхцөлтэй уялдуулан мах сүүний чиглэлийн фермерийн аж ахуй хөгжүүлэх ажлыг дэмжинэ.
- 2.1.3 “Агар-4” аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, аймгийнхаа гурилын дотоодын хэрэгцээг бүрэн хангана.
- 2.1.4 Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулж, зээлийн дэмжлэг үзүүлж, өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмэгдүүлнэ.
- 2.1.5 Зудын эрсдлийг даван туулах “ӨВӨЛЖӨӨ” төсөл хэрэгжүүлнэ.

А. Мал аж ахуй

- 2.1.6 Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, малын гаралтай бүтээгдэхүүнийг мөшгөх цахим тогтолцоог хөгжүүлнэ.
- 2.1.7 Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлж, малын эмч, мал зүйчдийг тэтгэлэгт хөтөлбөрөөр бэлтгэж, сум багийг мал аж ахуйн мэргэжилтнээр хангана.
- 2.1.8 Бэлчээр ашиглагчдын холбоо, дундын хоршоо, хот айлын гэх мэт малчдын хамтын нөхөрлөлийн хэлбэрүүдийг дэмжих, малаа чанаржуулах замаар малчдын орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.1.9 Малын чанар, үржлийн ажлыг сайжруулж, халдварт өвчнөөс ангид “Эрүүл, тайван аймаг” статусыг хадгалан, мал аж ахуйн эко бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортын чиглэлээр “Загвар аймаг” болно.
- 2.1.10 Орон нутгийн эрэлт хэрэгцээ, онцлогт нийцүүлэн малын үржил, селекцийн ажил, үйлчилгээг чанаржуулах, нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч, цэвэр үүлдрийн малын тоо толгойг өсгөнө.
- 2.1.11 Сумдад ажиллах малын эмч, мал аж ахуйн мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангана.
- 2.1.12 Аймгийн мал эмнэлэг, ариун цэвэр, оношилгооны лабораторын үйл ажиллагааг сайжруулах, стандартыг хангуулна.
- 2.1.13 Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангана. /сумдад мал эмнэлгийн оношилгооны анхан шатны лабораторуудыг байгуулах, мал амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах/
- 2.1.14 Мал эмнэлгийн үйлчилгээний норматив тарифыг орон нутаг дахь бараа ажил үйлчилгээний үнийн өөрчлөлттэй уялдуулан тухай бүрт нь шинэчлэн тогтооно.
- 2.1.15 Малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлийг баталгаажуулах, хяналт тавих тогтолцоог сайжруулна.
- 2.1.16 Залуу малчдыг малжуулах хөтөлбөрийг эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлж, малын тоо бус чанарыг чухалчилна.
- 2.1.17 “Залуу Малчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Газар тариалан

- 2.1.18 Улаангом дахь Газар тариалангийн эрдэм шинжилгээний салбарыг түшиглэн эрдэм шинжилгээ, туршилт судалгаа, үр үржүүлгийн төв болгох асуудлыг шийдвэрлэнэ.

- 2.1.19 Төмс, манжин, лууван, сонгино, байцаа зэрэг хүнсний ногооны үр үржүүлэх төвийг Улаангом суманд байгуулж, хүнсний ногооны чанартай үрээр Монгол улсын хэмжээний хэрэгцээг хангана.
- 2.1.20 Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх замаар нарийн ногоогоор дотоодын хэрэгцээг бүрэн хангах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.21 Газар тариалангийн бүс нутагт усжуулалтыг нэмэгдүүлж, үрийн шилмэл сортын нөөц бүрдүүлнэ.
- 2.1.22 Улаангом, Баруунтуруун, Тариалан, Өмнөговь сумдал стандартын механикжсан зоорь барьж төмс, хүнсний ногооны үнийг тогтворжуулж ажиллана.
- 2.1.23 Газар тариалангийн бүс нутгуудад ус хуримтлуулах сан, хөв цөөрөм байгуулах ажлыг нэмэгдүүлнэ.

2.2 Үйлдвэрлэлийн хөгжил

- 2.2.1 Малын гаралтай түүхий эд, дайвар бүтээгдэхүүнийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах үйлдвэрүүд, цогцолборыг сум дундын төвүүдэд байгуулахыг дэмжинэ. /Улаангом, Өмнөговь, Зүүнговь, Өндөрхангай, Баруунтуруун/
- 2.2.2 Өрхийн бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн өртөг шингэсэн үйлдвэрлэл эрхлэх, нэмүү өртгийн сүлжээнд хамрагдах санаачилгыг түлхүү дэмжиж, зээл, санхүүгийн хөнгөлөлттэй бодлого хэрэгжүүлнэ.
- 2.2.3 Цагаан ултай болон гутлын үйлдвэрлэлийг бүсийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн кластерийн загвараар хөгжүүлэх, түүхий эдийг дотоодоос хангах зорилгоор кластэр төвийг нээн ажиллуулж, арьс шир боловсруулах үйлдвэрийн технологийг сайжруулна.
- 2.2.4 Барилгын материалын үйлдвэрлэлийн хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлж, чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- 2.2.5 Жимс, жимсгэнэ, чацаргана, хүнсний ногоогоор эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн ундаа, шүүс боловсруулах шинэ технологи бүхий үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.3 Аялал жуулчлалын хөгжил

- 2.3.1 Аялал жуулчлалын гадаад, дотоод хамтын ажиллагаа, сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлж, үндэсний онцлог, ялгарал бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдийг түшиглэсэн тогтвортой эко аялал жуулчлалыг сумдад хөгжүүлэхийг бүх талаар дэмжинэ.
- 2.3.2 Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулж, жуулчдад үйлчлэх тур оператор компануудын тоог нэмэгдүүлж, зочид буудал, тээвэр, хоолны газруудыг олшруулж, үйл ажиллагааг нь сайжруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.3.3 Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу тогтоосон байршилд түр буудаллах үйлчилгээний цогцолбор байгуулна.
- 2.3.4 Увс, Хяргас нууруудыг өвөл, зуны амралт зугаалга, аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлж, Төв Азийн олон улсын аялал жуулчлалын хамтын ажиллагаанд нэгдэнэ.
- 2.3.5 Улаангом-Увс нуур чиглэлийн 25,84 км хатуу хучилттай авто замыг барьж, зам дагуух үйлчилгээг олон улсын жишигт хүргэн, “Аялал жуулчлал”-ын цогцолбор байгуулна.
- 2.3.6 Аймгийн төвд жуулчдад зориулсан орчин, худалдаа, үйлчилгээ бүхий гудамж байгуулна.
- 2.3.7 Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулах, авто зогсоол, үйлчилгээний төв, ариун цэврийн байгууламжийн бүтээн байгуулалтыг нэмэгдүүлнэ.
- 2.3.8 Аялал жуулчлалын салбарт ажиллагсадад зориулсан ногоон зээл, хөнгөлөлттэй зээлийн эргэлтийн сан бий болгоно.
- 2.3.9 Тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэн нутгийн иргэд, ААН-үүдийг аялалын маршрут гарган үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлнэ.
- 2.3.10 Тусгай сонирхлын аялал жуулчлалын бүх чиглэлийг дэмжин хөгжүүлнэ.

2.4 Инженерийн дэд бүтэц, эрчим хүчний хөгжил

- 2.4.1 Дулааны 2-р станцын зуухны хүчин чадал нэмэгдүүлнэ.
- 2.4.2 Улаангом хотын цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж өсөн нэмэгдэж буй хэрэглээний ачааллыг даахуйц, байгаль орчинд халгүй шийдлийг бий болгоно.
- 2.4.3 Улаангом сумын гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх ажлыг үргэлжлүүлж, гэр хорооллын айл өрхүүдийг цэвэр, бохир ус, халаалтын нэгдсэн шугамд холбох ажлыг хэрэгжүүлнэ.
- 2.4.4 Аймгийн төвийн гэр хороололд дахин төлөвлөлт хийх замаар орон сууцны хороолол барих ажлыг хэрэгжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.
- 2.4.5 Сумын төвүүдийн цэвэр, бохир усны шугам сүлжээг бага оврын цэвэрлэх байгууламжийн хамт бүрэн шийдвэрлэж инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх замаар байгууллага, аж ахуйн нэгжийн ажиллах нөхцөл, айл өрхийн ая тухтай амьдрах орчныг сайжруулна.
- 2.4.6 Сумдын хэрэглэгчдийг ЦЭХ-ний ухаалаг тоолуурт үе шаттай шилжүүлж айл өрхийн шөнийн эрчим хүчний тарифыг тэглэнэ.

2.5 Зам тээвэр, харилцаа холбооны хөгжил

- 2.5.1 Монгол улсын хөгжлийн баруун коридор болох БНХАУ-Монгол улс-ОХУ-ыг холбосон босоо тэнхлэгийн авто зам буюу Улаангом-Ховд аймаг чиглэлд хатуу хучилттай авто зам барьж /163.6 км/ улс хоорондын бараа эргэлт, худалдааны реэкспортыг нэмэгдүүлэхэд санаачлагатай хандаж, олон улсын тээвэр логистикийг хөгжүүлэхэд идэвхтэй хамтран оролцоно.
- 2.5.2 Бүсүүдийн хөгжлийг дэмжих аймгийн төв, сумдыг холбосон “ТАВАН ТОЙРОГ” автозамын төсөл хэрэгжүүлж, олон улсын болон улсын чанартай замын сүлжээг нэмэгдүүлэхийг дэмжиж, хамтран ажиллана.
- 2.5.3 Боршоо боомт, олон улсын цогцолборын үйл ажиллагааг дэмжиж, хил орчмын худалдааг хөнгөвчилж, Алтайн хязгаарын аялал жуулчлалын алтан цагаригт нэгдэн, аялал жуулчлалыг өргөжүүлж, хилээр нэвтрэх иргэдийн тоог нэмэгдүүлнэ.
- 2.5.4 Зүүн бүсийн сумдын чиглэлд Улаангом – Зүүнговь – Баруунтуруун сумыг холбосон хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулна.
- 2.5.5 Улаангом хот доторхи болон сум, аймаг хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.5.6 Сумын төвүүдийн тохижилтын ажлыг үргэлжлүүлж, бүх сумын төв гудамжийг бетон зам, гэрэлтүүлэг, явган хүний зам, дугуйн замтай болгоно.
- 2.5.7 Бүх сумдыг төв замтай хатуу хучилттай авто замаар холбож авто замын дэд бүтцийн нэгдсэн сүлжээнд холбоно.
- 2.5.8 Увс нуур чиглэлийн авто замыг ашиглалтад оруулна.
- 2.5.9 Тээлийн гүүрээс Боршоо боомт хүртэлх авто замын их засвар хийнэ.

ДӨРӨВ: ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1 Төрийн албаны хөгжил, гадаад харилцаа

- 3.1.1 Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүний оролцоогүй, хиймэл оюуны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадвар бүхий “ухаалаг E-Mongolia” системийг хөгжүүлэлтэд санаачлагатай оролцоно.
- 3.1.2 Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хандлагыг шинэчилнэ.
- 3.1.3 Сумдад төрийн албан хаагчдад зориулсан хөнгөлөлттэй нөхцөл бүхий орон сууц барьж эхэлнэ.
- 3.1.4 Хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ-ын муж, улс, аймгуудтай бүх салбарт харилцааг гүнзгийрүүлэхээс гадна худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.
- 3.1.5 Бусад улс орнуудын хот, мужуудтай харилцааг өргөжүүлж боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон бусад салбарын төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, төрийн албан хаагчдыг гадаадын улс орнуудад урт, богино хугацааны мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулна.
- 3.1.6 Төрийн байгууллагын албан хаагч нарын орон нутгийн цалингийн нэмэгдлийн ялгавартай байдлыг арилгаж 80-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ.
- 3.1.7 Шинэ бүтээн байгуулалт, орон сууцны барилга байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссын ажлын чанарыг сайжруулж үр дүнтэйгээр зохион байгуулна.

3.2 Аюулгүй, амар тайван орчинтой хүний эрхийг дээдэлсэн аймаг

- 3.2.1 Улаангом сумын гудамжны камержуулалтыг нэмэгдүүлэх, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулна.
- 3.2.2 Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, алдагдсан малыг олох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх сумдын бод малыг нэгдсэн бүртгэлд оруулна.
- 3.2.3 Тэс, Өмнөговь сумдад Гал унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах бүлэг шинээр байгуулна.
- 3.2.4 Онцгой байдлын газрын Баруунтуруун сум дахь Гал түймэр унтраах, аврах 60 дугаар ангийг Онцгой байдлын хэлтэс болгоно.

ТАВ: НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1 Байгаль орчны хөгжил

- 4.1.1 Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг засварлан, хамгаалалтын дэглэмийг мөрдүүлж, хүн амыг баталгаат ундны усаар хангана.
- 4.1.2 Хатуулаг ихтэй болон цэвэршүүлэх шаардлагатай ундны ус бүхий сумын төвийн гүн өрмийн худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах, гэр хорооллын худгуудад энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэн тоолууржуулна.
- 4.1.3 Хогийг анхан шатанд нь ангилан ялгаж, цуглуулах асуудлыг зөв менежментээр шийдвэрлэж “Хог” хөтөлбөр, ногоон эко-жорлонг ашиглах төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 4.1.4 Цөлжилтийг бууруулах, хөрс хамгаалах, байгаль орчинг сэргээх, агаарын чийгшлийг нэмэгдүүлэх, болзошгүй аюулаас сэргийлэхийн тулд тариалангийн талбайн хамгаалалтын зурвас байгуулна.
- 4.1.5 Аймгийн хэмжээнд амьтан, ургамал, байгалийн нөөцийн судалгаа хийлгэж, тархалт, нөөцийг тогтоох, ашигт ургамлыг тарималжуулах, нутагшуулах санаачилгыг дэмжинэ.
- 4.1.6 Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.
- 4.1.7 Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд халгүй аргаар тэмцэж холбогдох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 4.1.8 “Тэрбум” мод хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоо, цахилгаан, усны зардалтай уялдуулна.
- 4.1.9 Төрөөс баримталж буй ойн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 4.1.10 Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлогыг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, байгалийн нөөцийн менежментэд иргэдийн оролцоо чадавхийг бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.1.11 Байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар эдийн засгийн хөгжлийг хангах.
- 4.1.12 Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.1.13 Байгалийн үнэ цэнэ, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

4.2 Хариуцлагатай уул уурхай

- 4.2.1 Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэт техник технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.
- 4.2.2 Бичил уурхайтай холбоотой асуудлыг цэгцэлж, хууль, журмын дагуу үйл ажиллагааг нь дэмжиж, байгаль орчны нөхөн сэргээлтийг үр дүнтэй хийлгэж тэнд ажиллагсадыг хоёрдогч ажлын байраар хангаж хамтран ажиллана.

ЗУРГАА. СУМЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

6.1 “МИНИЙ ХАЙРТАЙ УЛААНГОМ” ЦОГЦ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ.

ИРГЭН БҮРИЙН ОРОЛЦООТОЙГООР “ШИНЭ УЛААНГОМ”-ЫГ ХАМТДАА БҮТЭЭЦГЭЭ.

- АЙЛ БҮРИЙН ХАШААНД ДЭД БҮТЦИЙН ШУГАМ ХҮРГЭНЭ.
- “1.000.000 МОД” – ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ УЛААНГОМЫГ “НОГООНГОМ” БОЛГОНО.
- “ХОГГҮЙ ХОТ – ШИНЭ УЛААНГОМ” ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ ХОГНЫ АСУУДЛЫГ БҮРЭН ШИЙДВЭРЛЭНЭ.
- АЮУЛГҮЙ, АМАР ТАЙВАН ОРЧИНТОЙ, АМЬДРАХАД ТААТАЙ УЛААНГОМ ХОТЫГ ХӨГЖҮҮЛНЭ.
- АМРАХ, АЯЛАХ, ЧӨЛӨӨТ ЦАГАА ӨНГӨРӨӨХ ЦОГЦ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ.

АЙЛ БҮРИЙН ХАШААНД ДЭД БҮТЦИЙН ШУГАМ ХҮРГЭНЭ.

- 6.1.1 Увс аймгийн Улаангом суманд байрлах дулааны 2-р станцын хүчин чадлыг нэмэгдүүлэн өргөтгөл хийж, дулааны шинэ станц барьж, үйлдвэрийн болон гэр хорооллын инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 6.1.2 Гэр хорооллын дэд бүтцийн ажлыг үргэлжлүүлж, айл бүрийг хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.1.3 Шинэ цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулан бохирын шугамын сүлжээний зарим хэсэгт өргөтгөл хийж гэр хорооллын айл өрхүүдэд хүрэх бохирын шугамыг нэмж тавина.
- 6.1.4 Улаангомьн дулааны шугамын зарим хэсэгт шугамын шинэчлэлийг үе шаттай хийнэ.

“1.000.000 МОД” – ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ УЛААНГОМЫГ “НОГООНГОМ” БОЛГОНО.

- 6.1.5 Айл өрх, албан байгууллагын мод тарих ажлыг бодлогоор дэмжиж Улаангом хотыг 1 сая модтой “Ногоон гом” болгоно.
- 6.1.6 Улаангом болон бүх сумдыг ногоон байгууламж төлөвлөлтийн нэгдсэн зурагтай болгоно.
- 6.1.7 Ногоон байгууламж, гудамж дагасан усалгааны системийг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- 6.1.8 Улаангомьн цэцэрлэгжүүлэлтийн арчлалт, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангана.
- 6.1.9 Аймаг сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулан шинэ таримал мод, сөөгний тарьц суулгац бэлтгэх Мод үржүүлгийн томоохон талбайг байгуулан, шинжилгээ судалгааны дэвшилтэд технологийг нэвтрүүлнэ.
- 6.1.10 Байгальд тулгуурласан ландшафт тохижилтыг тодорхой хэдэн газарт бий болгож нутгийн онцлог давуу төрхийг бий болгоно.

АЮУЛГҮЙ, АМАР ТАЙВАН ОРЧИНТОЙ, АМЬДРАХАД ТААТАЙ УЛААНГОМ ХОТЫГ ХӨГЖҮҮЛНЭ.

- 6.1.11 Улаангомьн гудамж талбайн болон гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, байнгын ажиллагаатай болгоно.
- 6.1.12 Улаангом сумын замын эвдрэл, хагарлыг засаж сайжруулах, тогтмол арчилгааны асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.1.13 Аймгийн төв, гэр хороолол, байр, гудамж талбайг бүрэн камержуулж ногоон бүс бий болгоно.

- 6.1.14 Улаангом сумын орон сууцны хорооллын цэвэр усны шугам хоолойг шинэчилж “зэс хоолой”-оор солих ажлыг эхлүүлнэ.
- 6.1.15 Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа зарим орон сууцнуудыг дахин төлөвлөлтөд оруулна.
- 6.1.16 Орон сууцнуудыг хариуцсан СӨХ байгуулж, төрөөс дэмжиж ажиллана.
- 6.1.17 Зарим орон сууцны зоорийн давхрын шугам сүлжээг шинэчилж, дээвэр, фасадны их засвар хийнэ.
- 6.1.18 Түрээсийн орон сууц шинээр барьж, зорилгот бүлгийн иргэдийг хамруулна.
- 6.1.19 Улаангомьн гэр хорооллын тохижилт, төлөвлөлтийг иргэдийн оролцоотой хийнэ.
- 6.1.20 Шинээр газар олгогдсон суурьшлын бүсэд цахилгаан хангамж хүргэж, хүчдэлийн уналттай хэсгүүдийг дахин төлөвлөнө.
- 6.1.21 Явган хүний зам, авто замын гарц, дугуйн зам, нийтийн эзэмшлийн зам талбайд дахин инженерчлэл хийж аюулгүй, ээлтэй орчин бий болгоно.
- 6.1.22 Улаангомьн үерийн усны сувагчлалыг шинээр төлөвлөж ажлыг эхлүүлнэ.
- 6.1.23 Өвөл зунгүй халуун устай байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.1.24 Улаангомьн нийтийн тээврийн төлөвлөлтийг шинэчилж, автобусны тоо, эргэлтийг нэмэгдүүлнэ.
- 6.1.25 Төвлөрсөн захуудад шинэчлэл хийж хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйд анхаарч ажиллана.
- 6.1.26 Хуучин гаражуудыг буулгаж ногоон байгууламж, авто зогсоол болгож орон сууцны орчныг шинээр төлөвлөн цэгцтэй, стандарттай болгоно.
- 6.1.27 Дулааны станцуудын янданг шүүлтүүртэй болгож агаар, орчны бохирдлыг бууруулна.

АМРАХ, АЯЛАХ, ЧӨЛӨӨТ ЦАГАА ӨНГӨРӨӨХ ЦОГЦ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ.


- 6.1.28 Баг бүрт хүүхдийн тоглоомын талбай шинээр барьж, ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэн, хүүхдийн чөлөөт цагаа өнгөрөөх аюулгүй орчныг бүрдүүлж ажиллана.
- 6.1.29 Аймгийн төвийн бүх багт стандартын 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулна.
- 6.1.30 Усан бассейн, театрын барилгыг ашиглалтад оруулна.
- 6.1.31 Автомашингүй гудамж – амралтын орчин би болгоно.
- 6.1.32 Аймгийн төвийн өнгө үзэмжийг сайжруулах, нийтийн эзэмшлийн талбай, байр, орон сууц, гэр хороолол, тоглоомын талбайг будах, арчлах ажлыг тогтмол хэрэгжүүлнэ.
- 6.1.33 Улаан уулын 2 талын авто замыг барьж ашиглалтад оруулан улаан уулыг тойрсон явган хүнийн зам, дугуйн замын сүлжээг бий болгоно.
- 6.1.34 Улаангомд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нүүхдийн паркийг шинэчлэх, “парк – цэнгэлдэх хүрээлэн – цэцэрлэгт хүрээлэн” гэсэн амралт, зугаалга, тоглоомын цогц орчин бий болгоно.

“ХОГГҮЙ ХОТ – ШИНЭ УЛААНГОМ” ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ ХОГНЫ АСУУДЛЫГ БҮРЭН ШИЙДВЭРЛЭНЭ.

- 6.1.35 Аймгийн төвийн хогны менежментийг шинэчлэн хийж хоггүй хот болгоно.
- 6.1.36 Хогны хөтлийг аймгийн төвөөс холдуулан шинээр төлөвлөж, хогийг устгах, булшлах, цэвэрлэж хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулна.
- 6.1.37 Нийтийн эзэмшлийн гудамж талбай, тоглох, амарч зугаалах орчинд хогийн савны тоог нэмэгдүүлж, иргэн бүр хог хаяхгүй байх СОЁЛТОЙ болгох төсөл, нөлөөллийн ажил зохион байгуулна.

БУСАД АСУУДЛУУД

- 6.1.38 Улаангомьн хот тохижилтын газарт цогц шинэчлэл хийж, төсвийг нэмэгдүүлэн үйл ажиллагаа, менежментийг шинэ түвшинд хүргэнэ.

- 
- 6.1.39 Шинэ суурьшлын бүсийг дахин төлөвлөж газар олголтын хүртээмжийг нэмэгдүүлж иргэн бүр газартай болох боломжийг нээж өгнө.
- 6.1.40 Ашиглагдахгүй байгаа газруудыг дахин төлөвлөх замаар эдийн засгийн эргэлтэд оруулна.
- 6.1.41 Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн агро парк байгуулж бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжиж ажлын байр нэмэгдүүлнэ.
- 6.1.42 “Чимээгүй хот”-ын менежментийг сайжруулж энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.

6.2 Сумдад хэрэгжүүлэх зорилгууд

- 6.2.1 Сумын төвийг бүрэн камержуулж ногоон бүс бий болгоно.
- 6.2.2 Сумын төвүүдийн тохижилтын ажлыг үргэлжлүүлж, төв гудамжийг бетон зам, гэрэлтүүлэг, явган хүний зам, дугуйн замтай болгоно.
- 6.2.3 Бүх сумдад стандартын 3x3 сагсан бөмбөгийн талбай байгуулна.
- 6.2.4 Зарим сумын төвд залуу гэр бүл, төрийн албан хаагчдад зориулсан нийтийн орон сууц барих ажлыг эхлүүлнэ.
- 6.2.5 Зарим сумын төвийн 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд өргөтгөл, хүчитгэх шинэчлэл хийнэ.
- 6.2.6 Сумдын нэгдсэн халаалтын сүлжээг өргөтгөж айл өрхүүд холбогдох боломжийг нэмэгдүүлнэ.
- 6.2.7 Айл өрх, албан байгууллагыг төвлөрсөн цэвэр, бохир усны сүлжээнд холбож нэгдсэн цэвэрлэх байгууламжийн асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.2.8 Сумдын хэрэгцээ шаардлагыг үндэслэн зарим сумдын ЗДТГ, сургууль, цэцэрлэг, дотуур байр, соёлын төв, ЭМТ-ийн барилгын их засвар, өргөтгөл, шинээр барих ажлыг эрэмбэлэн үе шаттай хийж хэрэгжүүлнэ..
- 6.2.9 Сум тус бүрийн онцлог, давуу талд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Ялангуяа малын гаралтай түүхий эд, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 6.2.10 Сумдын усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж тэжээлийн аж ахуй бий болгоно.
- 6.2.11 Сумдад хүн амын ундны болон мал амьтан, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 6.2.12 Сумдын халуун усны үйл ажиллагааг дэмжиж тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.2.13 Ашиглалтын хугацаа дууссан болон ашиглахгүй хаягдсан барилгуудыг буулгаж цэгцлэн сумын өнгө үзэмжийг сайжруулна.
- 6.2.14 Сумдын үүрэн холбооны сүлжээгүй цэгүүдэд сүлжээ хүргэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,
Утас/факс: 7045-3317,
Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2025.04.22 № 291
танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН БАРУУНТУРУУН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ “АРДЧИЛСАН НАМ”-ЫН
УДИРДЛАГА ТАНАА

Хандивын тайлангийн дүгнэлт

Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Увс аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох Ардчилсан нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6 дахь заалтад заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Увс аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

8525020897

Дүгнэлт

Ардчилсан нам нь ээлжит бус, нөхөн болон дахин сонгуульд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ





**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,
Утас/факс: 7045-3317,
Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2025.04.22 № 293
танай _____-ны № _____-г

УВС АЙМГИЙН БАРУУНТУРУУН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
“АРДЧИЛСАН НАМ”-ЫН УДИРДЛАГА
ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-д заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох “Ардчилсан нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тус тус шалгуур болгон авч үзсэн.

8525020883

Дүгнэлт

“Ардчилсан нам”-ын Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


“Ардчилсан намын”-ын мөрийн хөтөлбөр хуудас материал хавсаргав.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



М.БАТСУУРЬ

М.БАТ-АМГАЛАН

Б.АВИРМЭД

Р.АЮУШ

Б.ОДГЭРЭЛ

Т.БАТСҮХ

УВС АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН 2025 ОНЫ ОРОН НУТГИЙН
НӨХӨН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



1. Боловсрол

- 1.1 Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох “Монгол гэр бүл” боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2 Хүүхдийн хөгжлийг дэмжих, авьяас чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн “Ном”, “Авьяас”, “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3 Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүүхэд бүрд цахим төхөөрөмж” /Таблет, зөөврийн болон суурин компьютер/ хөтөлбөр хэрэгжүүлж сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- 1.4 Сургууль, цэцэрлэгийн багш нарыг компьютер, сургалтын дэвшилтэт тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангаж, багшийн хөгжил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн “Оюунлаг багш” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.5 Сургалтын байгууллагын өрсөлдөх чадвар, хөгжлийн дэмжсэн” Сайн сургууль, цэцэрлэг” хөтөлбөр хэрэгжүүлж, сумдын сургалтын байгууллагуудын боловсролын чанарын ялгааг арилгана.
- 1.6 Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, удирдах албан тушаалтныг чөлөлөх, томилох асуудалд аймаг, сумын иргэдийн төлөөллөөс бүрдсэн “Боловсролын зөвлөл” –ийн саналыг харгалздаг болно.
- 1.7 Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт заавал судлан үзэх хичээлийн тоог цөөрүүлж, сонгон судлах хичээлийн тоог нэмэгдүүлнэ.
- 1.8 Хүүхэд, залуучуудад боловсрол эзэмшихэд нь туслах боловсролын тэтгэлэг, зээл, сангийн үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгж, хувь хүнийг дэмжин урамшуулж хамтран ажиллана.
- 1.9 Элсэлтийн ерөнхий шалгалт, олон улс, улсын чанартай олимпиад, уралдаан, тэмцээнд амжилт гаргасан сурагч, багш, бэлтгэсэн багш нарт олгох урамшууллыг нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлнэ.
- 1.10 Хүүхэд залуус, төрийн албан хаагчдын гадаад хэлний боловсролыг дэмжих “Англи хэлний хөтөлбөр” хэрэгжүүлнэ.
- 1.11 Багш, суралцагч, эцэг эхийн хамтын ажиллагаа, хөгжлийг дэмжихүйц сургалтын цахим лаборатори, видео, хичээл, цахим сурах бичиг, онлайн сургалт, виртуал, орчин бүхий сургалтын нээлтэй тогтолцоог дэмжсэн “Дижитал боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.12 Инженерчлэл, техник технологийн төрөлжсөн бүсийн хэмжээний их, дээд сургууль байгуулах, дээд боловсролын сургалтын хосолсон хөтөлбөрүүдийг дэмжиж, хамтран ажиллана.
- 1.13 Улаангом политехник коллежийн сургалтын хөтөлбөрийг шинэчилж, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн шинэ ангиуд нээнэ.
- 1.14 Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, иргэдийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлж, насан туршийн суралцахуйн нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлнэ.
- 1.15 Улаангом хотод олон улсын их сургуулиудын салбар бүхий оюутны хотхон байгуулах санал, санаачлагыг дэмжиж, хамтран ажиллана.
- 1.16 Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлж, нэг ангид ногдох хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлнэ.
- 1.17 Сургуулийн байршлаас хамааран хүүхдийг аюул, эрсдлээс хамгаалах зорилгоор “Сургуулийн автобус” төслийг хэрэгжүүлнэ.
- 1.18 Дотуур байрны үйл ажиллагаа, бүтэц, орон тоо, чиг үүргийг өөрчилж, орчин нөхцлийг сайжруулж, эрүүл мэнд, биеийн тамир, монгол ахуй, ёс заншил, өөртөө болон бусдад үйлчлэх үйлчилгээ бүхий “Хүүхэд хөгжлийн төв” болгон ажиллуулна.
- 1.19 Олон нийтийн эх хэлний боловсролыг дээшлүүлж, монгол бичгийн хэрэглээг бүх түвшинд нэвтрүүлнэ.
- 1.20 Орон нутгийн төсвөөс боловсролын салбарын багш, ажилтны орон нутагт ажилласны нэмэгдлийг үе шаттайгаар нэмэгдүүлэн олгоно.

2. Эрүүл мэнд

- 2.1. Эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх төвийн үйл ажиллагааг бие даасан хэлбэрээр зохион байгуулж, иргэдээ эрт илрүүлэг, үзлэг, оношилгоонд бүрэн хамруулна.
- 2.2. Эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн үйлчилгээг шинэчлэн зохион байгуулж, яаралтай тусламжийн чиглэлээр мэргэшсэн багийн шуурхай бэлэн байдлыг хангаж ажиллуулна.
- 2.3. Тэтгэвэр тогтоолгосон эмч, сувилагч нарыг эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөхөөр ажиллуулахыг бодлогоор дэмжинэ.
- 2.4. "1000 сувилагч" сургах, бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.5. Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийг дэмжих "Сүү" хөтөлбөрийг сургууль, цэцэрлэгүүдэд хэрэгжүүлнэ.
- 2.6. "Эрүүл шүд – Эрүүл хүүхэд" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.7. Сум бүрд шүдний кабинет байгуулахыг дэмжинэ.
- 2.8. Аймгийн Нэгдсэн эмнэлгийг судасны MRI оношилгооны тоног төхөөрөмжтэй болгож, хот руу явж оношлуулах, эмчлүүлэх зардал, чирэгдлийг бууруулна.
- 2.9. Эрүүл мэндийн байгууллагуудыг алсын зайн оношилгооны тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.10. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах, гадаад болон дотоодод багаар нь сургах ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.
- 2.11. Багийн эмч нарыг бүрэн автомашинтай болгох ажилд дэмжлэг үзүүлнэ.
- 2.12. Орон нутгийн төсвөөс эрүүл мэндийн салбарын эмч, ажилтны орон нутагт ажилласны нэмэгдлийг үе шаттайгаар нэмэгдүүлэн олгоно.

3. Хөдөлмөр эрхэлт, нийгмийн хамгаалал

- 3.1. Баялаг бүтээгчдээ дэмжиж, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.2. Гадаад, дотоодын сургуульд суралцаж, ажиллаж байгаа болон нутагтаа эргэн ирж ажиллаж байгаа залуучуудад зориулсан "Зөгий үүрэндээ" хөтөлбөр хэрэгжүүлж, сум, багт ажиллах залуучуудыг бодлогоор дэмжинэ.
- 3.3. "Хөдөлмөр эрхлэлтийн сан"-гийн олон эх үүсвэрээс ажлын байр бий болгож, жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, хил орчмын худалдаанд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.
- 3.4. Насан туршийн суралцахуйн төв болон коллежид залуучууд, ахмадуудад ур чадвар олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.5. Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлж, гарааны бизнесийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.6. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлж, "Ахмад мэргэжилтний алба" ажиллуулах санаачилга, хөдөлгөөнийг дэмжинэ.
- 3.7. "Хүүхдийн мөнгө" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.8. Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх, иргэн аж ахуйн нэгж байгууллагыг дэмжинэ.
- 3.9. Өрх, суманд 0-5 насны хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан сэргээн засах, эмчилгээ сувилгааны төв байгуулна.
- 3.11. Ахмад настанд зориулсан сэргээн засах эмчилгээ, сувилгааны төвийг байгуулж, сумдын ахмадын байрны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 3.12. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, тэдний нийгмийн үйл ажиллагаанд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, авьяас чадвараа хөгжүүлэх боломжийг дэмжсэн сайн дурын клубуудын үйл ажиллагааг дэмжинэ.
- 3.13. Цалин хөлсийг ажлын байранд өнгөрүүлсэн хугацаагаар бус ажлын үр дүнгээр тооцдог аргачлал нэвтрүүлж, цагаар ажиллах, зайнаас ажиллуулах зэргээр хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэрийг дэмжих замаар эмэгтэйчүүд, оюутан залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

- 3.14. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг нь хангана.
- 3.15. Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулж, ил тод, нээлттэй, чирэгдэлгүй болгоно.

4. Соёл урлаг, биеийн тамир спорт

- 4.1. Соёлын биет болон биет бус язгуур өв соёлоо хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлж, өв өвлөн уламжлагчдаа дэмжсэн бодлого баримтална.
- 4.2. Баруун монголын өв соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, уламжлалт арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 4.3. Үндэсний соёлын агуулга бүхий кино, контент, тайз, дэлгэцийн бүтээлийг бодлогоор дэмжиж, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 4.4. Иргэдийн соёлын бүтээлч үйлдвэрлэл, түүний эдийн засаг, санхүүгийн эргэлтэд оруулах байдлыг урамшуулан дэмжинэ.
- 4.5. Төр, хувийн хэвшил, спортын холбоодын түншлэлийн хүрээнд нийтийн биеийн тамир, спортыг бүх талаар хөгжүүлэхэд хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ.
- 4.6. Хүүхэд залууст зориулсан спорт цогцолбор, талбай, усан бассейн, сургалтын төв, баг бүрд спорт тоглоомын талбай байгуулах зэрэг барилга байгууламжийн дэд бүтцийн төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- 4.7. Аймгийн өсвөрийн шигшээ багийг байгуулж, баг, тамирчдад дэмжлэг үзүүлж, спортын үндсэн төрлүүдийг хөгжүүлнэ.
- 4.8. Олон улс, улс, бүсийн хэмжээний томоохон уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 4.9. Улаангом хотод "Өвлийн спортын бааз" байгуулахыг дэмжиж ажиллана.
- 4.10. Аймаг, сум, байгууллагын түүхэн ойг өв соёл, зан заншил, түүх, бүтээн байгуулалтыг салбар бүрээр "100 эрхэм иргэн", "100 бүтээн байгуулалт" зэрэг бүтээл бий болон олны хүртээл болгохыг ажлыг дэмжинэ.
- 4.11. Хүүхэд, залуучуудын ордон байгуулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

5. Хөдөө аж ахуй, үйлдвэржилт

- 5.1. "Шинэ хөдөө-Увс" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.2. "Хариуцлагатай, чинээлэг малчин" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 5.3. "Ногоон бүс-эрүүл мах" хөтөлбөр хэрэгжүүлж, малчин өрхийг орлогыг нэмэгдүүлнэ.
- 5.4. Мал, мах бэлтгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох замаар мал нядлах, ангилан савлах, консервлах үйлдвэр байгуулж, мах тээвэрлэх, борлуулах сүлжээг өргөтгөн ОХУ-д мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх, малчдын орлогыг тогтвортой нэмэгдүүлэх "Монгол мах" брэндийг дэмжинэ.
- 5.5. Мал эмнэлгийн үйлчилгээг сум, багийн малчдад ойртуулж, чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд мал эмнэлгийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 5.6. Сум бүрд хөргүүртэй агуулах байгуулах, ноос, малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалт хийх, өндөр ашиг шимтэй мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.
- 5.7. Баруун бүсийг гурил, тэжээлээр хангах үйлдвэрийг Баруунтуруунд байгуулна.
- 5.8. Чацаргана боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, жимсний борлуулалтыг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.
- 5.9. Аймгийн томоохон голуудыг дагасан өндөр ашиг шимт тэжээлийн ургамал тариалах усжуулалтын системийг байгуулж, эргэлтийн талбайг 5000 га-аар нэмэгдүүлж, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.
- 5.10. Бордооны үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 5.11. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолбор бүхий "Увс -Агро" төслийг хэрэгжүүлнэ.
- 5.12. Баруун бүс нутгийн худалдааны чөлөөт бүсийг хөгжүүлнэ.

- 5.13. Орон нутгийн бренд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн кластер "УВС" брэндийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.14. Бизнес инкубатор төвийн үйл ажиллагааг өргөтгөж, гарааны бизнес эрхлэгчдийг чадавхжуулж, дэмжлэг үзүүлнэ.
- 5.15. Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих дэд сан бий болгож хамтран ажиллана.
- 5.16. Давс, нүүрс, төмрийн хүдэр зэрэг ашигт малтмалын боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлийг дэмжиж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.
- 5.17. Шинжлэх ухаан, инновацын төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж, дэвшилтэт болон шинэ технологийг орон нутгийн тэргүүлэх салбаруудад нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

6. Дэд бүтэц, бүтээн байгуулалт

- 6.1. Баруун бүсийн босоо тэнхлэгийн зам дагуух тээвэр логистикийн төвийг Улаангомд байгуулна.
 - 6.2. Гэр хороололд чиглэсэн дулаан, цэвэр, бохир ус, цахилгаан, авто замын дэд бүтцийг өргөтгөж, айл бүрийг хашаандаа сайхан амьдрах боломж нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 6.3. Сумдын төвийн гэр хорооллын инженерийн дэд бүтцийн ажлыг /Баруунтуруун, Давст, Наранбулаг, Түргэн, Өмнөговь, Өндөрхангай сум/ дэмжиж, сайжруулна.
 - 6.4. Сургууль, дотуур байр, цэцэрлэгийн барилгыг шинэчлэх, өргөтгөх, засвар тохижилтын ажлыг хийж, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангана.
 - 6.5. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг шинэчлэх, засвар, тохижилтынажлыг хийж, шаардлагатай тоног төхөөрөмж, автомашинаар хангана.
 - 6.6. Сумдын соёлын төв, спортын ордон, нийтийн номын сан, музей зэрэг байгууллагуудын барилгыг шинэчлэн барих, засвар тохижилт хийх, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангана.
 - 6.7. Зоонозын өвчин судлалын төвийн барилгыг шинэчлэн барина.
 - 6.8. Аймгийн төвийн авто замыг сайжруулж, "Гудамж" төслийг хэрэгжүүлнэ.
 - 6.9. Сумдыг Улаангомтой хатуу хучилттай авто замаар холбох /Баруунтуруун, Бөхмөрөн, Тэс, Завхан, Тариалан, Түргэн, Сагил/ ажлыг хэрэгжүүлнэ.
 - 6.10. Улаангомоос Боршоо боомт чиглэлийн хатуу хучилттай авто замыг өргөтгөн шинэчилнэ.
 - 6.11. Ховд-Улаангомыг холбосон авто зам, Увс нуур чиглэлийн авто замын ажлыг бүрэн дуусгана.
 - 6.12. Улаангом сумын 9,10,12-р багийн гэр хороолол, Улаантолгойн үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барьж, засварлана.
 - 6.13. Аймгийн төвийн 35/10кВ-ын цахилгаан хангамжийн хуваарилах байгууламж, дэд станцын өргөтгөл /Сагил, Тариалансум/ барьж, Бөхмөрөн сумын Гурванжигэртэй багийг цахилгаан эрчим хүчинд холбоно.
 - 6.14. Улаангом сумын 3, 10, 9, 12-р багийн гэр хорооллын цахилгааны шугамын өргөтгөл хийнэ.
 - 6.15. Шинээр 60 МВт-ын цахилгаан станц барих төслийн ажлыг эхлүүлнэ.
 - 6.16. Аймгийн төвийн бохир, цэвэр усны байгууламжуудыг шинэчлэн өргөтгөнө.
 - 6.17. Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж, ахмад настан, өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.
 - 6.18. Аймгийн хэмжээнд 1500 өрхийг орон сууцжуулж, орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг орон сууцтай болгох санал, санаачилгыг дэмжиж ажиллана.
 - 6.19. Улаангомын хуучин орон сууцны барилгыг дахин төлөвлөх, нийтийн орон сууцны гадна тохижилтыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
 - 6.20. Улаангомын Дулааны 2-р станцын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- ## 7. Байгальторчин, аялал жуулчлал
- 7.1. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

- 7.2. Уур амьсгалын өөрчлөлт, ойжуулалт, байгаль хамгаалал, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлд анхаарсан ногоон хөгжлийн бодлого гарган хэрэгжүүлнэ.
- 7.3. Аймаг, сумын гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Жорлонго өөрчилъе төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулж, сургууль, цэцэрлэг дотуур байр, эрүүл мэндийн төвүүдийг стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжаар бүрэн хангана.
- 7.4. Яндан, нүхэн жорлонг жилд 10-аас доошгүй хувиар бууруулна.
- 7.5. Аймгийн төв, суурин газруудад хог хаягдал боловсруулах байдлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж, эко орчин бүрдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 7.6. Увс, Хяргас нуур зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн спорт, эрүүл мэнд, амралт, сувилал, эко туризм, өв соёлын аялал жуулчлалын цогцолбор байгуулах иргэд, аж ахуйн нэгжийн санаачилга, хөрөнгө оруулалт, оролцоог дэмжиж ажиллана.
- 7.7. Аялал жуулчлалын бүс нутагт отоглох цэгүүд байгуулж, тохижуулна.
- 7.8. Аялал жуулчлалын салбарт ажиллагсдын ур чадварыг сайжруулах арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулж, үйлчилгээний соёл, стандартыг мөрдүүлнэ.
- 8. Хууль, шударга ёс**
- 8.1. Төрийн албан тушаалтан, даргын эрх мэдлийг хамгаалсан төрийн бодлогыг өөрчилж, иргэний эрхийг хамгаалсан, иргэдэд үйлчилдэг бодлоготой болно.
- 8.2. Авлигатай тэмцэх, албан тушаалын гэмт хэргийн эсрэг "Авлигагүй аймаг" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 8.3. Төрийн албаны сонгон шалгаруулалтыг шударгаар, нээлттэй явуулдаг болгоно.
- 8.4. Хүний эрх, хүйсийн тэгш байдлын талаарх иргэдийн боловсролыг дээшлүүлж, жендерийн тэгш бус байдал, хүчирхийллийг арилгахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 8.5. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангана.
- 8.6. Төрийн албан хаагчийн ажлын чиг үүргийг оновчтой болгож, ёс зүй, сахилга хариуцлагыг чангатгана.
- 9. Ухаалаг засаглал**
- 9.1. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай, иргэдийн оролцоотой, төсөв санхүүгийн бодлогыг ил тод, нээлттэй хэрэгжүүлнэ.
- 9.2. Гадаад, дотоодын бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлж, олон улс, бүсийн төрөлжсөн аргах эмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохионбайгуулна.
- 9.3. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын болон орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.
- 9.4. Төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, хүний эрх, цахимз асаглалыг дэмжсэн "Цахим Увс" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 9.5. Төр, хувийн хэвшлийн байгууллагуудад "Стандартай Увс" хөтөлбөрийг хэрэгжүүлж, чанарын удирдлагын тогтолцоог сайжруулж, холбогдох стандартыг мөрдүүлнэ.
- 9.6. Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 9.7. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын цахим систем /Egr Mongolia/ бүрэн нэвтрүүлж, ажлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,
Утас/факс: 7045-3317,
Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2025.04.22 № 294
танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН БАРУУНТУРУУН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
"ХҮН НАМ"-ЫН УДИРДЛАГА ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-д заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох "ХҮН НАМ"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тус тус шалгуур болгон авч үзсэн.

8525020882

Дүгнэлт

“ХҮН НАМ”-ын Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“ХҮН НАМ”-ын мөрийн хөтөлбөр хуудас материал хавсаргав.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



М.БАТСУУРЬ

М.БАТ-АМГАЛАН

 Б.АВИРМЭД

Р.АЮУШ

 Б.ОДГЭРЭЛ

Т.БАТСҮХ



ХҮН

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ХҮН НАМ

АГУУЛГА

| | |
|--|-------------------------------------|
| ОРШИЛ | Error! Bookmark not defined. |
| I. ХҮНДЭЭ ЗОРИУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ..... | Error! Bookmark not defined. |
| II. ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН | Error! Bookmark not defined. |
| III. ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ ЭЗЭМШИХ | Error! Bookmark not defined. |
| IV. БАЙГАЛЬД ОЙР МОНГОЛ ЗАГВАР..... | Error! Bookmark not defined. |
| V. ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | Error! Bookmark not defined. |

ОРШИЛ

ХҮН намын 2024 оны Монгол Улсын аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан баримт бичиг болно.

Монгол оронд сүүлийн жилүүдэд үүссэн ардчиллын болон тогтолцооны гажуудлыг засч, үндэсний язгуур эрх ашиг, түүх соёл, уламжлал, эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, дэлхийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хүний хөгжил, хууль ёс, шударга ёс, нийгмийн ардчиллыг дээдэлсэн хүмүүнлэг, аз жаргалтай нийгмийг цогцлоон байгуулах зорилгоор, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны зорилтыг ханган биелүүлэх хүрээнд, нотолгоонд суурилж, судалгаанд үндэслэн энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулав.

Монгол Улсын 21 аймаг, тэдгээрийн сумд төлөвлөснийхөө дагуу хөгжиж, дэлхийн хөгжилтэй мөр зэрэгцэн алхъя гэвэл дотоодын жижиг зах зээлд хоорондоо хэт өрсөлдөж, хүч нөөцөө барах бус, олон улсын зах зээлд өрсөлдөх зарчмыг баримтлах нь чухал тул тулгарч буй асуудлаа эрэмбэлж, орон нутгийн хөгжлийн стратеги боловсруулах шаардлагатай.

Хөгжлийн стратеги нь нэн тэргүүнд аймаг, сумын иргэн хүний төлөө хүний хөгжлийг эн тэргүүнд тавьж, бусад салбаруудыг хөтлөх, хөгжлийн салхийг чиглүүлэх юм. Монгол Улсын орчин, нөхцөл байдал, дэлхийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзвэл дараах 3 чиглэл онц ач холбогдолтой бөгөөд эдийн засаг, нийгмийг хөгжлийн замд гаргахад түлхэц болно гэж бид үзэж байна. Үүнд:

- (1) **Хүний хөгжил.** Боловсрол, эрүүл мэнд, хүний хөгжилд тууштай, бодитой хөрөнгө оруулах. Нэгд, энэ асуудал өнөөдрийн Монгол улсад, аймаг орон нутагт нэн тулгамдсан, хойш тавих боломжгүй асуудал, хоёрт, дунд болон урт хугацаанд олон том асуудлын шийдэл нь хүний хөгжил юм.
- (2) **Технологийн хэрэглээ.** Блокчэйн, хиймэл оюун ухаан, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын технологийн шийдлүүд, нанотехнологи, биотехнологи, хөдөө аж ахуй, эрчим хүч, химийн болон бусад салбарт технологийн дэвшлийг төр, бизнесийн бүх түвшний хэрэглээнд хурдтай бөгөөд бусдаас өрсөн шийдэмгий нэвтрүүлэн, өрсөлдөөний давуу талыг олж, үр шимийг нь түрүүлж хүртэнэ.
- (3) **Байгальд ойр Монгол.** Байгаль дэлхийтэйгээ шүтэн барилдсан уламжлалт монгол сэтгэлгээ, нүүдлийн соёл, амьдралын амар тайван хэв маягийг технологийн шийдэлтэй хослуулан хотын гэр хорооллыг хөгжүүлж, дэлхий дахинд ялгарах шинэ Монгол дүр төрх бүрдүүлнэ.

Аймгийн иргэдэд хурд, хүч, ялгарлыг өгөх дээрх гурван тулгуурт үндэслэн нэн тэргүүнд хэрэгжүүлэх ёстой бодлогын арга хэмжээг дараах 6 бүлэгт ангилан оруулав. Үүнд:

1. **Хүндээ зориулсан хөрөнгө оруулалт** – Хот, орон нутгийн хөгжлийн ялгааг бууруулна
2. **Эдийн засаг, бизнесийн таатай орчин** - Эдийн засгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна
3. **Дэвшилтэт технологийг эзэмших** - Шилдэг шинэ технологийг нэвтрүүлж орчин үетэй хөл нийлүүлж хөгжинө.
4. **Байгальд ойр Монгол загвар** - Унаган байгаль ба түргэн хөгжлийг хослуулж, хүн амын эрүүл ахуйн баталгааг тогтвортой хангана.
5. **Иргэдэд хүртээмжтэй төрийн үйлчилгээ** – Төрийн үйлчилгээг иргэн тус бүрд тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэнэ.

І. ХҮНДЭЭ ЗОРИУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хот, орон нутгийн хөгжлийн ялгааг бууруулна

Аймаг, орон нутгийн хөгжил

- Хүн ам цөөтэй, эх газрын эрс тэс уур амьсгалтай, экологийн эмзэг орчин бүхий уул, тал хээр, говь цөл хосолсон өргөн уудам нутагтай Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлж, засаг захиргааны олон жижиг нэгжийг томсгон, сум дундын болон аймгийн, бүсийн төвүүд зэрэг хот суурин газрыг хөгжүүлснээр хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгах бодлого баримтална.
- Орон нутгийн өөрийн удирдлагын эрхийг нэмэгдүүлж, малын хөлийн татварыг хөдөө орон нутгийн хөгжилд зарцуулах эрхийг тухайн орон нутагт нь олгох, тухайн бүсийн байгалийн баялгийн нөөцийг ашигласны эцсийн үр өгөөжийг ахиу хүртээх, байгаль орчныг хамгаалах нийтлэг асуудлыг аймаг, сум, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хамтын хүчээр шийдвэрлэж, экологийн тэнцвэртэй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Малчид, мал аж ахуйн хөдөлмөр эрхлэгчдийн ахуй соёл, нийгмийн хангамжийг шинэ шатанд гаргах бодлого баримтална.
- Орон нутгийн зарим ахлах сургуулийн хөтөлбөрт малчин бэлдэх чиглэлээр хэсэгчлэн төрөлжүүлэх бодлогыг баримталж ажиллана.
- Сургуулийн өмнөх, суурь, бүрэн дунд, ахлах сургуулийг төрөлжүүлж, мэргэшсэн боловсон хүчин бэлдэх сургалтыг нэвтрүүлнэ.
- Сайн сургуулийн жишгийг нэвтрүүлж, багшлах боловсон хүчний хангамжийг сайжруулна.
- Залуучуудын амьдралын хэв маягийг эергээр өөрчилсөн бодит бүтээн байгуулалтууд, чөлөөт цагийн орон зайг мэргэжлийн төлөвлөлт, дизайнаар бүтээн байгуулж тасралтгүй тордон сайжруулах менежменттэй болгоно.

Аймгийн төв, суурин газарт эрүүл, тохилог орчныг бүрдүүлж хөгжүүлнэ

- Төв, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх бодлого баримтална.
- Төв, суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна.
- Төв, суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг нэмэгдүүлж, хог хаягдлыг дахин боловсруулж, агаар орчны бохирдлыг бууруулна.
- Орон сууцны хороолол, гэр хорооллын дунд ногоон байгууламж, соёл, спортын төвүүдийг байгуулах талаар хүн амын тоо, нягтаршилтаас хамааруулан хүртээмжтэй байх ажлыг зохион байгуулж мөрдүүлнэ.

- Иргэд, хүүхдүүдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, нийтийн үйлчилгээний газар, орон сууцны нийтийн эзэмшлийн талбай зэрэгт эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын стандартыг чанд мөрдүүлж ажиллана.
- Спорт цогцолбор, биеийн тамирын заал, талбай, цэцэрлэгт хүрээлэн, дугуй болон дугуйн төрөлт тээврийн замыг 1000 хүн тутамд нэг байхаар байгуулах зорилт тавьж, энэхүү зорилтод хүрэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлнэ.
- Аймаг, сумдын хүүхэд залуучууд, ахмад настнуудад зориулсан сургалт, соёл, хөгжлийн төвүүдийг дэмжих арга хэмжээ авна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг хангах чиглэлээр олон улс болон Монгол Улсын хууль, журмыг баримталж, нийтийн тээвэр, үйлчилгээний газар, сургууль цэцэрлэг, барилга байгууламж зэрэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан норм дүрмийг мөрдүүлнэ.
- Төрийн байгууллагуудын барилгуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 100 хувь хүртээмжтэй болгоно.

Цэцэрлэг, сургуулийн сургалтын орчныг сайжруулна

- Цэцэрлэг, сургуулийн эргэн тойрны газар ашиглалтын байдалд аудитын дүгнэлт хийлгэж, төрөөс хүүхдэд таатай гадаад орчин бүрдүүлэхэд анхаарна.
- Орон нутгийн цэцэрлэг, сургуулийн ашиглалтыг сайжруулна.
- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдүүдийг бүрэн хамруулах зорилгод хүрэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэлнэ.
- Нэг ээлжид хичээллэдэг тогтолцоог зорилт болгон энэхүү зорилтод хүрэх арга хэмжээг авч эхлүүлнэ.
- Цэцэрлэг, сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурах, ашиглах бүрэн боломжтой байх стандартыг нэвтрүүлж хэвшүүлнэ.

Боловсролын тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

- Алслагдсан бүс нутагт амьдарч байгаа хүүхэд, залуучуудын боловсролд онцгой анхаарч, зайны сургалтын орчин үеийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Алслагдсан бүсэд багшлах багш нарыг бодлогоор дэмжиж, ажиллана.
- Багшийг дахин сургах, гадаадад сургах, туршлага солилцуулах хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Сургуулийн барилгын стандартыг шинэчилж, зураг төслийн зардлыг хэмнэх зорилгоор орон нутгийн онцлогт тохирсон ижил стандартуудтай болгоно.
- Боловсролын тэгш хүртээмжтэй байдлыг хангах, чанарыг дээшлүүлэх зорилгоор зайн сургалт, онлайн сургалтыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.
- Сургуулийн орчныг өндөр хурдны интернэтэд бүрэн холбох, сургалтад ашиглах боломжийг бүрдүүлж ажиллана.

- Англи хэлийг албан ёсны хоёрдогч хэл болгох бодлогыг тууштай баримтална.
- Багшийн үнэлэмжийг хамгийн өндөрт тавьж цалинг нэмэгдүүлнэ.
- Малчдын хүүхдийг эцэг эхийнхээ дэргэд бага боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх бодлого баримтална. Сургууль-Эцэг эх-Сурагчийн гурвалсан харилцаанд суурилсан сургалтын эрүүл орчныг улс орон даяар нэвтрүүлнэ.
- Монгол бичгээр гарч буй агуулга, мэдээллийг олшруулах, нийтийн өргөн хэрэглээг нэмэгдүүлэхийг бүхий л талаар дэмжиж ажиллана.
- Нийт суралцагчдад Оюун ухаан-Бие бялдар-Сэтгэлийн тэнцвэртэй боловсролыг олгох болон хүүхэд бүрийн сэтгэхүй, сэтгэл зүйн онцлог, авьяас чадварт суурилан бэлтгэхэд чиглэсэн иж бүрэн “Боловсролын реформ”-ыг хэрэгжүүлнэ.
- Боловсролын бодлого улс төрөөс ангид, тогтвортой байх зарчмыг хэвшүүлнэ.
- Сургуулийн өмнөх боловсролыг “хүүхдийг сургах, сургуульд бэлтгэх” гэсэн зорилгоос илүүтэйгээр хүн болон төлөвших үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих, насан туршийн боловсролын суурь үе хэмээн хөгжүүлнэ.
- Шавь төвтэй, бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх сургалтын арга барилыг бэхжүүлнэ.
- Бүх шатны боловсрол олгоход технологийн болон байгалийн ухааны сургалтын чанарыг дээшлүүлж, сургуулиудад байгалийн ухаан, хөгжим, технологийн хичээлийн лаборатори байгуулах ажлыг төсвөөр дэмжих асуудлыг шийдвэрлүүлнэ.
- Аймгийн хэмжээнд “Хос хэлтэн” болох зорилт тавьж, зохих бэлтгэл ажлыг хэрэгжүүлнэ. Гадаад хэлний мэдлэгийг түлхүү анхаарч, танхимын болон онлайн сургалтыг эрчимтэй нэвтрүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлээс үл хамаарсан тэгш хамруулах сургалтыг ерөнхий боловсролд бүрэн нэвтрүүлэхийг дэмжинэ.
- Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалтыг арилгах, хүүхдэд аюулгүй цахим орчныг бүрдүүлнэ.
- Хүүхдийн зүй бус, албадан хөдөлмөр, мөлжлөгийг устгах, сургууль завсардалтыг үндсээр нь халахад анхаарч ажиллана.

Эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулж, эрүүл мэндийг хамгаалах бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлнэ

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төсөв санхүү, нөөцийг нэмэн өргөжүүлж иргэдэд хүртээмжтэй ойртох нөхцөлийг бий болгоно. Аймгийн эрүүл мэндийн төвийн бодлого, төсөв, санхүүжилт, үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байдлыг бий болгох, авлига, ашиг сонирхлыг устгах, эрүүл мэндийн салбарын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр ашгийг эрс сайжруулах бодлого баримтална.
- Эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, салбарын шинэ технологи нэвтрүүлэх сонирхлыг нэмэгдүүлэх хөшүүргийг оновчтой нэвтрүүлж, уламжлалт анагаах ухааныг орчин үеийн шинжлэх ухаантай зөв хослуулна.
- Эмнэлгийн оношилгоонд хиймэл оюун ухаан, инноваци технологийг нэвтрүүлж, явуулын оношилгооны лаборатори болон эмнэлгийг орон нутагт бүрэн нэвтрүүлнэ.

- Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, эмчилгээний үйлчилгээг хөгжүүлж, олон нийтэд хүртээмжтэй, боловсронгуй болгоно.
- Архи, тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис, бусад төрлийн донтолт, хорт зуршлын хамааралтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх тогтолцоог сайжруулах, архидалттай тэмцэх, архидалтыг сурталчилсан үүсмэл зан заншлыг халах, архидалтын эсрэг эмчилгээг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.
- Бүх шатны эмнэлгийн байгууллагын ажилтнууд, эмч, сувилагчдын нийгмийн байр суурь, үнэлэмж, хүндлэлийг нэмэгдүүлэх, эрүүлийг хамгаалах мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлнэ.
- Эмч, сувилагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургалт, гадаад болон дотоод туршлага солилцох хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Эрүүл мэндийн салбарт оруулах дотоод гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримтална.
- Эрүүл мэндийн санхүүжилтийн бүтцийг оновчтой болгох замаар, эрүүл мэндийн даатгалын бие даасан байдлыг бэхжүүлэн, иргэд эрүүл мэндийн үйлчилгээг оршин суугаа газрын харьяалал, өмчийн хэлбэр үл харгалзан эрүүл мэндийн даатгалаараа бүх шатлалын үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авч эхлүүлнэ.
- “Эрүүл Монгол” хөтөлбөрийн хүрээнд хүүхэд, өсвөр настны бие, сэтгэлийн эрүүл мэндэд онцгой анхаарч, хар тамхины хор хөнөөлийн талаарх мэдлэгийг дээшлүүлж архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- “Эрүүл мэнд эрхэм баян” хөтөлбөрөөр ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ойртуулж, амьдралын чанарыг нь дээшлүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- “Сэтгэл эрүүл Монгол хүн” хөтөлбөрөөр Монгол хүний бие, сэтгэлийн эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Цэмцгэр гэр хороолол

- Аймаг, сумын төвийн гэр хороолол хөрөнгө оруулалтын гадна үлдэж хоцордог шударга бус байдлыг эцэслэж, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах суурь хэрэгцээг бүрдүүлэхэд хөрөнгө хуваарилалтыг чиглүүлэх бодлого баримтална.
- Агаар ба хөрсний бохирдлыг бүрэн шийдвэрлэх зорилгоор гэр хорооллыг хувийн сууц, нийтийн орон сууц хосолсон тохилог хороолол болгох хөтөлбөр хэрэгжүүлж эхэлнэ.
- Гэр хороололд мод, ургамал тарих, арчлахад иргэд, байгууллагуудыг бодлогоор дэмжинэ.

Орон сууцны хороолол

- Нийтийн орон сууцны хуучирсан барилгуудын гаднах фасадыг шинэчилж, стандартад нийцүүлэн дулаалж, сантехникийн шугам сүлжээг шинэчлэх замаар орон сууцны

насжилтыг уртасгах ажлыг Зүүн Европын улсуудын жишгээр төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах бодлого баримтална.

- Орон сууцанд дулааны тоолуур тавих замаар өртөг зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- Залуу гэр бүлийн орлогод нийцсэн орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх бодлого баримтална.



II. ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН

Эдийн засгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна

Эдийн засаг, бизнест тэгш боломж, шударга өрсөлдөөнийг бий болгох зарчмыг мөрдлөг болгон, хөдөлмөрлөсөн нь сайхан амьдардаг, хичээсэн нь амжилт гаргадаг, боломж чадвараар дутуугаа гээдэггүй, хүний наад захын эрэлт хэрэгцээ хангагдсан, шударга нийгмийг цогцлон байгуулна.

- Иргэн бүрд жигд боломж, нөхцөлийг олгосон баялгийн шударга хуваарилалтыг хэрэгжүүлж, авлигаас ангид бие даасан, хэсэг бүлэг этгээдийн шунал, хүсэлд захирагдаагүй сахилга баттай шударга чөлөөт зах зээлийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэл хийх бодлого баримтална. Салбарын болон орон нутгийн хэрэгцээ шаардлагыг бодитоор тооцоолж, улсын нийгэм эдийн засгийн хөгжилд түлхэц болох төслүүдийг эрэмбэлэн санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр болон санхүүжилтийг ил тод болгоход анхаарч ажиллана.
- Төрийн санхүүжилттэй нийтийн чанартай төсөл, засгийн газрын ханган нийлүүлэлтийн төслийн бараа үйлчилгээний тендер, худалдан авалтыг шударга явуулахад онцгой анхаарч, хэрэгжилтийг ил тод, олон нийтийн хяналтын дор явуулна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, үр чадвартай залуу үеийг төлөвшүүлж, бүрэн хөдөлмөр эрхлэлттэй улс болохын төлөөх бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.
- Эдийн засаг, бизнест хэт дарамт учруулахгүй, энгийн ойлгомжтой, үр нөлөө бүхий бизнесийн шударга орчин, шударга өрсөлдөөнийг бий болгох саналыг боловсруулж хүргүүлнэ.
- Нийгмийн баялгийг зохистой, шударга хуваарилах, эдийн засгийн хөгжлийг тэтгэх бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжиж, бага хүүтэй урт хугацааны зээл авах боломжоор хангах, ажлын байр нэмэгдүүлэх хөшүүрэг болгох арга хэмжээ авна.
- Ядуурлаас гарахад зориулсан мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулж, сургалтыг төрийн зүгээс тогтмол явуулдаг болно. Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд орох боломжийг бүрдүүлэх, цаашлаад ажил хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.
- Бага насны хүүхэд ядууралд өртөх, хүнс тэжээлийн дутагдалд орох, орон гэргүйн улмаас амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал нь эрсдэх нөхцөл байдлыг арилгахыг зорино.
- Бизнес эрхлэгчдэд гадаад түншүүдтэй харилцахад нь дэмжлэг үзүүлэх, гадаад зах зээлийн талаарх мэдээллээр хангах төр, хувийн хэвшлийн оролцоотой бүтцийг бий болгон экспортын баримжаатай хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлнэ.

Мал аж ахуйн эдийн засгийн үр ашгийг сайжруулж, малчдын бодит орлогыг нэмэгдүүлнэ.

- Хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйг тэргүүн ач холбогдол бүхий салбарын түвшинд авч үзэж хөгжүүлэх бодлого баримтална.
- Уламжлалт нүүдлийн мал аж ахуй болон хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх бодлого баримтална.
- Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.
- Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан төв, суурин газруудын ойролцоо эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлэх бодлого баримтална.
- Арьс шир, мах, сүү, ноос зэрэг малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах санаа санаачилгыг дэмжиж, малчдын бодит орлогыг нэмэгдүүлнэ.
- Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдаа, хорио цээрийн шаардлагад нийцсэн мал, амьтны өвчингүй статустай нутгийн хэмжээг нэмэгдүүлж, мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг хөрш орнуудын зах зээлд гаргах мал эмнэлгийн эрүүл ахуйн зохистой орчинг бүрдүүлэх, үндэсний мал, амьтны эмнэлгийн үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулна.
- Мал аж ахуй, хөдөө аж ахуйн эрүүл бүсийг бий болгож, баталгаажуулна. Мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийг экспортлоход тэргүүн ач холбогдол өгнө.
- Сум болгонд малын эрүүл ахуйг хангах, түүхий эд цуглуулах төвүүдийг өмчийн олон хэлбэртэйгээр байгуулж хөдөө аж ахуйн биржтэй хослон ажиллуулах бодлого баримтална.
- Мал аж ахуйг байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах зах зээлийн зарчимд нийцсэн даатгалын тогтолцоо бүрдүүлнэ.
- Мал аж ахуйн салбарт “Монгол өрх - үндэсний хөгжлийн загвар аж ахуй” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд талуудын оролцоог ханган хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулагч, үйлдвэрлэгч, хэрэглэгч, зах зээлтэй тэднийг холбох кластерын платформыг хөгжүүлнэ. Мөн нийлүүлэлт, үйлдвэрлэл, логистик болон маркетингийн нэгдсэн систем бүхий платформыг үүсгэн байгуулна.

Бизнес эрхлэлт, үйлдвэрлэлийн хөгжлийг бодлогоор дэмжинэ.

- Бизнесийн салбарт бизнес эрхлэх шударга, тогтвортой орчныг бүрдүүлж, компанийн засаглал, бизнесийн ёс зүйг сайжруулж, зөвлөх үйлчилгээг дэмжинэ.
- Мэдлэг, инновацийг дээдэлсэн эдийн засгийн ач холбогдолтой бизнесийн төслүүдийг дэмжинэ.

- Дотоодын нөөц бололцоогоор хийх боломжтой ажлын байрыг хамгаалж, өөрийн орны иргэдийг ажиллуулах, эрэлт хэрэгцээ өндөртэй болон ирээдүйд шинээр бий болох ажлын байруудад боловсон хүчнийг сургах, бэлтгэх бодлого баримтална.
- Хүйтнийг даван туулах технологийг бүхий л талаар дэмжин, дулаан алдагдал багатай барилгын материал үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого баримтална.
- Хөдөө аж ахуйд суурилсан, нэмүү өртөг шингэсэн экспортын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үе шат руу шилжих, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжсэн бизнесийн орчныг бүрдүүлнэ.
- Шударга өрсөлдөөнд суурилсан компани төвтэй кластерууд хөгжих боломжийг бүрдүүлж, мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээ, банк санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангах, төв, суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлэх, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа мах болон сүүний тодорхой хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулна.
- Хүнсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Цахим худалдаа, үйлчилгээг хөгжүүлж, газарзүйн байдалтай холбоотой бизнесийн өртөг, зардлыг хямдруулна.
- “Сумын хөрөнгө оруулалтын сан”-гаар дамжуулан малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.

Аялал жуулчлал

- Манай улсын харьцангуй давуу тал болох аялал, жуулчлалын үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, экспортын орлогын тогтвортой эх үүсвэр болгох бодлого баримтална.
- Аялал жуулчлалын үйлчилгээний олон улсын стандартыг нэвтрүүлж, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулна. Аялал жуулчлалын олон төрөл, улирлын онцлогтой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого баримтална.
- Жуулчдын статистик бүртгэл хөтлөх, судалгаа хийх тогтолцоог бэхжүүлж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал, нүүдлийн соёл иргэншлийг танилцуулах жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх бодлого баримтална.

- Орчин үетэй зохицон хөгжиж буй нүүдлийн соёл, ахуйтай танилцах болон байгаль орчинд ойр, эрүүл амьдралын хэв маягийг мэдрүүлсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлнэ.
- Музей, соёл урлаг, түүх, уламжлалт зан заншлыг хамарсан зөөлөн хүчний бодлогыг аялал жуулчлалтай уялдуулна.



III. ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ ЭЗЭМШИХ

Шилдэг шинэ технологийг нэвтрүүлж орчин үетэй хөл нийлүүлж хөгжинө

- Монголын уламжлалт нүүдлийн ахуйд цахим технологи, эрчим хүчний эх үүсвэр, цэвэр усан хангамж, түүхий эд боловсруулах бичил үйлдвэрлэл мэт орчин үеийн технологийн ололтыг нэвтрүүлэх, малчдын эрүүл, тохитой орчинд амьдрах, хөгжих, аж ахуй эрхлэх боломжийг сайжруулах, энэ чиглэлд оруулсан хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- Хиймэл оюун ухаан, блокчэйн зэрэг аж үйлдвэржилтийн тавдугаар хувьсгалыг бий болгож буй шинэлэг технологиудыг эзэмших ур чадварыг хүүхэд залууст олгох зорилгоор мэргэжлийн их дээд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт тусгаж өгнө. Чадварлаг багшлах боловсон хүчнийг олон улсад дээрх чиглэлээр мэргэшин суралцахад тэтгэлэг олгоно.
- Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлнэ. Орон нутгийн бүх түвшинд интернэт, компьютер, технологийн хэрэглээг түлхүү ашиглах, интернэт орчныг хямд, хурдтай байлгах, мэдээллийн технологи хөгжих суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
- Эрчим хүчний олон төрлийн эх үүсвэрийг ашиглах, бага, дунд оврын үүсгүүрийн технологи хөгжүүлэх, нэвтрүүлэхийг дэмжих бодлого баримтална.
- Мэдээллийн технологийн чиглэлээр ажиллаж буй дотоодын компаниуд, мэргэжлийн холбоодыг дэмжиж чадавхжуулах бодлого баримтална.
- Эмнэлгийн оношилгоонд хиймэл оюун ухаан, инноваци технологийг нэвтрүүлж, явуулын оношилгооны лаборатори болон эмнэлгийг орон нутагт бүрэн нэвтрүүлнэ.
- Төрийн байгууллагын үйлчилгээг цахимжуулснаар иргэд хурдан шуурхай үйлчилгээ авах боломж бүрдэнэ. Төрийн бүх шатны үйлчилгээг цахимаар авахад интернет үйлчилгээ, датаг үнэ төлбөргүй болгож, хүртээмжийг эрх тэгш болгоно.
- Орон нутгийн болон нийслэлийн төсөв, тэдгээрийн үйл ажиллагаанд иргэд цахимаар санал илгээх, оролцох, хяналт тавих нэгдсэн системийг бий болгоно.
- Технологийн боловсрол, тэр дундаа мэдээллийн технологийн боловсролыг бага наснаас эхлэн бүх шатны сургалтын агуулгад системтэйгээр түлхүү оруулах бодлого баримтална.
- Технологийн боловсрол олгох зориулалттай лаборатори болон бусад сурах орчныг орчин үеийн шийдлийг ашиглан сургалтын байгууллагуудад эрчимтэй нэвтрүүлнэ.
- Онлайн сургалт. Хөгжлийн хандлагыг даган танхимын бус, зөвхөн хүүхэд залуус биш бүх насны хүмүүст зориулсан онлайн, эчнээ сургалтуудыг нэвтрүүлэх, хүн өөрийгөө хөгжүүлэх боломжийг технологид суурилан олноор бий болгоно.

IV. БАЙГАЛЬД ОЙР МОНГОЛ ЗАГВАР

Унаган байгаль ба түргэн хөгжлийг хослуулж, хүн амын эрүүл ахуйн баталгааг тогтвортой хангана

Байгалийн нөөцийн болон бэлчээрийн менежмент

- Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.
- Биологийн олон янз байдал, экосистем, байгалийн үзэсгэлэнт газар, соёлын өвийг тодотгосон тогтвортой аялал жуулчлалын туршлага, санаачилгыг дэмжиж хөгжүүлнэ.
- Монгол орны 70 гаруй хувийг хамардаг бэлчээрийн өөрийнх нь сэргэх чадавх болон малчдын хамтын оролцоонд тулгуурлан нутгийн тогтвортой ашиглалтыг хангах хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлого баримтална.
- Монгол орны бэлчээрийн талхлагдал, доройтол цаашид газар авахаас сэргийлэх, мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг хангахад тулгуур ач холбогдол бүхий “Бэлчээрийн тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- Ойжуулалт, нөхөн сэргээлт, тогтвортой газар тариалан эрхлэх зэрэг газрын тогтвортой менежментийн сайн туршлагыг дэлгэрүүлнэ. Эвдэрсэн газрыг сэргээх хөдөө аж ахуйн арга техникийг хэрэгжүүлэх, нүүрстөрөгчийг шингээх, экосистемийн уян хатан чанарыг нэмэгдүүлэхийн тулд хөрс, газрыг хамгаалах хүчин чармайлтыг дэмжинэ.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж ажиллана. Мод ургуулах ажлыг тодорхой хэмжээгээр бизнес, арилжааны хэлбэрт шилжүүлэх, гадаад дотоодын хувийн санхүүжилт, ногоон бонд, хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэх, дэмжих чиглэлээр анхаарч ажиллана.
- Монгол орны үл олборлогдох нөөц төдийгүй хөдөөгийн хөгжил, үндэсний соёлын өв болсон бэлчээр нутгаа хадгалан хамгаалах “Бэлчээр ашиглалтын тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- Дахин сэргээгдэх ан агнуурын нөөцийн менежментийг хөгжүүлж, орон нутгийн хөгжлийг дэмжинэ. Байгалийн нөөцийн тогтвортой менежментийн эдийн засгийн үндсийг бүрдүүлж, орлогыг шударга хуваалцах, ил тод байх зарчмыг нэвтрүүлнэ.
- Хог хаягдлыг бууруулах, ангилан хаях, дахин ашиглах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хог хаягдлыг цуглуулах бодлогыг ядуурлыг бууруулах үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлнэ.
- Байгаль дахь хог хаягдлыг арилгах, түүж цуглуулах бодлогыг боловсронгуй болгож, аялал жуулчлалын орлогоос хог хаягдлыг бууруулах менежментийг санхүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
- Усны бохирдлыг бууруулна. Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн зохих хувийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах аймгийн хэмжээний усан сан байгуулах арга хэмжээнүүдийг авч эхэлнэ.
- Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлж, ариун цэврийн байгууламжийн шүүлтүүрийн үйл ажиллагааг сайжруулна.
- Хаягдал усыг цэвэршүүлэх, саарал ус ашиглах, хурын усыг хуримтлуулах гэх мэт усны хэмнэлттэй технологи нэвтрүүлэх арга хэмжээг авна.
- Аймгийн төвийн ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгохыг бодлогоор дэмжиж, төв, суурин газрыг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг бууруулах бодлогыг баримтална.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхыг бэхжүүлж, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын байгууллагаар дамжуулан олгох бодлого баримтална.
- Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт малчин айлд очих, тодорхой хугацаанд ажиллаж, ахуй соёлоос суралцах байгаль орчноо хамгаалах агуулгыг нэвтрүүлэх асуудлыг дэвшүүлнэ.
- Байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлнэ.
- Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах бодлого баримтална.

V. ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Төрийн албан хаагчийг дэмжиж, төрийн үйлчилгээг шинэчлэх бодлого хэрэгжүүлж, цахимжуулна. Авлигын эсрэг нийтийн хөдөлгөөнийг дэмжинэ.


- Төрийн албыг улс төрийн нам, улс төрчдийн нөлөөлөл, дарамтаас ангижруулан, бүтэц, зохион байгуулалтын хувьд оновчтой болгож, орон тоог боломжит доод хэмжээнд хүртэл бууруулан бүтээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Төрийн албан хаагчдыг бэлдэх, тасралтгүй давтан сургахад анхаарч ажиллана.
- Төрийн жинхэнэ албан хаагч нь чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу ажиллах боловч төрийн албыг чадавхжуулж, хөдөлмөрийн зах зээл дээрээс шилдэг мэргэжилтнүүдийг татан оролцуулах боломжийг бүрдүүлэхийн тулд сонгон шалгаруулалтаар (тусгай шалгалт) төрийн албаны зохих түвшинд орж ажиллах бодлогийг хэрэгжүүлнэ.
- Төрийн ёс зүй, сахилга бат, хариуцлага, мэдлэг чадвар, чармайлт бүхий төрийн тогтвортой албан хаагчдыг төлөвшүүлэн хөгжүүлэх бодлого, зорилт тавьж хэрэгжүүлнэ.
- Төрийн албан хаагчид тавигдах шалгуурыг өндөрсгөх, тэднийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд төрийн албан хаагчдын нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг нэмэгдүүлнэ.
- Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.
- Төрийн үйлчилгээг цахимжуулж, ил тод нээлттэй болгож, хүнээс хамаарах хамаарлыг багасгаж, хүнд суртлыг бууруулах бодлого баримтална.
- Авлига төрийн албанд голдуу үүрлэсэн боловч хүүхэд, залуу үеэ авлигач сэтгэлгээ суухаас сэргийлэх, өөрийн мэдэлгүй буруу хэвшил сургаж буй дадал, соёлыг засах, ухуулга, сургалт таниулга хийх, олон нийтийн хөдөлгөөн болгох, нийгмийн бүх гишүүдийн оролцоо, дэмжлэгийг авна.
- Уул уурхайн хөрөнгө оруулагчид орон нутагтай хамтран ажиллах нэрийдлээр орон нутгийн засаг захиргаа, иргэдэд шууд болон шууд бус татаас, хандив өгч авлигажсан сэтгэлгээ, орчин бүрдүүлдгийг цэгцэлж, илт тод, иргэдэд болон нийтэд өгөөжтэй болгон журамлах бодлогыг баримталж ажиллана.
- Төрийн үйл ажиллагааны ил тод байдлын зарчмыг бодитой хэрэгжүүлж, төрийн болон байгууллагын нууцын тухай хуульд зохих өөрчлөлт оруулж, иргэдийн мэдэх эрхийг хангана.

Үр дүнд чиглэсэн төсвийн сахилга батыг хангаж, төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж олон нийтийн хяналтад оруулна.

- Үр дүнд чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлж, бүсчилсэн хөгжилд тулгуурласан засаг захиргааны оновчтой тогтолцоог нэвтрүүлэх замаар төсвийн урсгал зардлыг бодитоор бууруулна.
- Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компанийн орлогоор төсөл, хөтөлбөр шууд санхүүжүүлдэг байдлыг зогсоож, бизнесийн зарчмаар бие даан үйл ажиллагаагаа

ил тод явуулах нөхцөлийг хангаж, ашгийг нөгдөл ашиг хэлбэрээр төсөвт төвлөрүүлэх, санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг төсвийн хүрээнд баталдаг байх

- Орон нутгийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар сонгон ажиллуул
- Орон нутгийн өмчит компаниудын хөрөнгө, үйл ажиллагаанд аудит хийх, санхүү, нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлнэ.



Шударга, ёс зүйтэй Монгол нийгмийг бүрдүүлнэ.

- Шударга ёсыг бэхжүүлэх, авлигыг устгах чиглэлээр боловсрол, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээг хамарсан цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Ёс зүйтэй Монгол хүн, Монгол нийгмийг төлөвшүүлэх бодлого баримтална.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ. Нийгмийн хөгжил дэвшилд жендерийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх орчныг бүрдүүлнэ.
- Хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн ялгааг бууруулах, хөдөлмөрийн зах зээл дээр шинэ боломжийг нээж өгнө.
- Хүн худалдаалах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэнэ.
- Ёс суртахууны доройтол, архидалт, мансуурал, садар самуун зэрэг нийгмийн гаж үзэгдэлтэй хуулийн хүрээнд тууштай тэмцэж нийгмийг эрүүлжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгааг нь хангана.
- Байгаль орчны болон хүнс, эм, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг эрс чангатгана.

----- о 0 о -----



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,
Утас/факс: 7045-3317,
Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2025.04.22 № 290
танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН БАРУУНТУРУУН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
“ХҮН НАМ”-ЫН УДИРДЛАГА ТАНАА

Хандивын тайлангийн дүгнэлт

Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох ХҮН намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Увс аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох ХҮН нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6 дахь заалтад заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Увс аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох ХҮН намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

8525020893

Дүгнэлт

ХҮН нам нь ээлжит бус, нөхөн болон дахин сонгуульд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,
Утас/факс: 7045-3317,
Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2025.05.02 № 309
танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН БАРУУНТУРУУН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЭЭЛЖИТ БУС, НӨХӨН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БИЕ ДААН
НЭР ДЭВШИГЧ Ц.ЛУВСАНДОНДОГ
ТАНАА

Хандивын тайлангийн дүгнэлт

Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Ц.Лувсандондогийн ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Увс аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Ц.Лувсандондог нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6 дахь заалтад заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг бие даан нэр дэвшигч хүлээнэ.

Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчид иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Бие даан нэр дэвшигч Ц.Лувсандондогийн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Увс аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Ц.Лувсандондогт иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар

зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Ц.Лувсандондог нь ээлжит бус, нөхөн сонгуульд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,
Утас/факс: 7045-3317,
Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2025.05.02 № 310
танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН БАРУУНТУРУУН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЭЭЛЖИТ БУС, НӨХӨН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БИЕ ДААН
НЭР ДЭВШИГЧ Ц.ЛУВСАНДОНДОГ
ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-д заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баруунтуруун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Ц.Лувсандондогийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тус тус шалгуур болгон авч үзсэн.

8525020941

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Ц.Лувсандондогийн орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



М.БАТСУУРЬ

М.БАТ-АМГАЛАН

Б.АВИРМЭД

Р.АЮУШ

Т.БАТСҮХ

Увс аймгийн Баруунтуруун сумын ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч ЦЭГМЭД овогтой ЛУВСАНДОНДОГ-
ийн мөрийн хөтөлбөр

2025.04.21

Баруунтуруун

❖ **Мөрийн хөтөлбөрийн зорилго**

Нэг. Хүний хөгжил, хэрэгцээг хангах, ажил үйлчилгээг иргэдийн амьдралд бодит өөрчлөлт дэвшил гаргана.

Хоёр. Иргэдийн хэрэгцээ санал санаачлагад тулгуурласан бодлогоор аймгийн жишиг сум болгон хөгжүүлж ард иргэдийг аюулгүй эрүүл хүнсээр хангахад дэмжиж ажиллана.

Гурав. Иргэдийнхээ эрх ашгийг дээдэлсэн, шударга ёс, ил тод, шуурхай үйлчилгээг орон нутагт төлөвшүүлнэ.

Нэг. Хүн амын хөгжил нийгмийн бодлого

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эмнэлгийн орчин цагийн төхөөрөмжийн шинэчлэлийг бий болгох

1.1.1 Эрүүл мэндийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх боломжит нөхцлийг ханган ажиллана.

1.1.2 Цэцэрлэг сургуулийн насны хүүхдийн шүд, амны хөндийг эрүүлжүүлэх, мөн иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг системтэйгээр зохион байгуулна.

1.1.3 Эмч эмнэлгийн ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулахад анхаарна.

1.2 БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж сургалтын таатай орчинг бүрдүүлэх

1.2.1 Улс, аймаг, сумын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан тэмцээнд оролцож амжилт үзүүлсэн сурагч, багш, багийг дэмжиж урамшуулна.

1.2.2 Сургуулийн дотуур байрны амьдрах, сурах орчныг ая тухтай, аюулгүй орчин нөхцөлөөр хангахад дэмжиж ажиллана.

1.2.3 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, цагаан идээний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

1.3 СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Соёл, спорт, аялал жуулчлалын ажлуудыг иргэд олон нийтэд хүртээмжтэй болгож, үйлчилгээний чанарыг эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулна.

1.3.1 Сумын спорт холбоодуудтай хамтарч шаардлагатай түвшинд дэмжиж ажиллана.

1.4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРЭЭНД

Нийгмийн хамгаалал, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.4.1 Сумын ахмад настан, иргэдийн амрах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх бололцоогоор хангаж, ахмадын сувилал бий болгоход анхаарч ажиллана.

1.4.2 Сумын ажилгүй иргэдийн судалгаа явуулж үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэх иргэдийг хөтөлбөрт хамруулж дэмжин ажиллана.

1.4.3 Сумын хөдөлмөр эрхлэх насны иргэдийн ажлын байр бий болгох, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх сургалтанд хамруулж дэмжиж ажиллана.

Хоёр. Эдийн засаг хөгжлийн бодлого

2.1 ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1.1 Мал амьтны гаралтай арьс шир, ноос ноолуур, мах сүү боловсруулах жижиг цех, үйлдвэрийг бодлогоор дэмжин төсөл хөтөлбөрт хамруулна.

2.1.2 Зоорь, хүлэмж, агуулахын аж ахуйг нэмэгдүүлэх замаар сумын хүнсний ногооны хэрэгцээг жилийн хугацаанд тогтвортой хангах боломжийг нэмэгдүүлнэ.

2.1.3 Сумын газар тариалан, мал аж ахуй, төмс хүсний ногоо үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг засгийн газар, аймгийн бодлоготой уялдуулан дэмжиж “Баруунтуруунд үйлдвэрлэв” брэнд бүтээгдэхүүн бий болгоход дэмжин ажиллана.

2.1.4 Сумын төвд ойн зурвас байгуулж улмаар хүүхэд залуусын цэцэрлэгт хүрээлэн бий болгох өргөтгөх ажлыг эхлүүлнэ.

2.2 ДЭД БҮТЭЦ

Дэд бүтцийн төлөвлөлтийг сайжруулж сум орон нутагаа хөгжүүлнэ.

2.2.1 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар ашиглалтыг сайжруулж, газрын зөрчил арилгах ажлыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж, газрын шинэтгэлийг эрчимжүүлнэ.

2.2.2 Сумын зорчих хэсгийн үер усанд идэгдсэн газрууд, нийтийн хогийн нэгдсэн цэгийг жил бүр сэргээн сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулна.

2.2.3 Сумын төвд үерийн ус зайлуулах шугам сүлжээг бий болгох асуудлыг судлан хэрэгжүүлнэ.

2.3 ТӨСӨВ САНХҮҮ

2.3.1 Төсвийн орлогын төлөвлөлтийг үндэслэлтэй хийж гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан албад, тасгуудтай хамтран татварын өр авлагыг барагдуулах замаар татвар хураалтыг сайжруулан орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллана.

2.3.2 Сумын иргэдийн дэмжлэгээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр жилд нэг томоохон ажлын байр бий болгож цаашид тогтмол үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.3 Сумын орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэгээр Шанд багт хүүхдийн тоглоомын талбайг тохижуулна.


Гурав. Нутгийн захиргаа хууль, эрх зүйн ажил үйлчилгээ

3.1. Нутгийн захиргааны ажил үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай, хариуцлагатай болгон төр иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлнэ.

3.2. Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж төрийн албан хаагчийн ажлын хариуцлага, ёс зүйг сайжруулах талаар хамтран ажиллана.

3.3. Хүний эрхийг хангахад нутгийн захиргаа, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж ажиллана.

Увс аймгийн Баруунтуруун сумын ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч Ц.ЛУВСАНДОНДОГ



Ц.Лувсандондог